



**2025 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## НЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Компанийн товч танилцуулга

#### Алсын хараа

Монгол Улсын хөгжил, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж, хариуцлагатай уул уурхайг түүчээлсэн үлгэр жишээ компани байна. Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулж, баялгийг бүтээлцэнэ. Монгол Улсын үнэт металлын хайгуул, олборлолт, үйлдвэрлэлийг Олон Улсын жишигт хүргэнэ.

#### Уриа үг

ЭХ ОРНЫ ЭРДЭНЭС-ИРЭЭДҮЙН БАЯЛАГ

#### Эрхэм зорилго

Бид тогтвортой, хариуцлагатай үйлдвэрлэлийг эрхэмлэн үндэсний баялгийг бүтээнэ. Бид Олон Улсын стандартад нийцсэн эрэл хайгуулыг хийж, алтны нөөцийг нэмэгдүүлэн, ард иргэдийнхээ эрх ашгийг дээдлэн, хууль журмын хүрээнд ажиллаж, эх орныхоо баялгийг нийтэд эрх тэгш хүртээнэ. Байгалийн баялгийн нөөц боломжийг зохистой ашиглах хүрээнд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэн, аюулгүй, шударга, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд дэвшилтэт техник технологи, мэргэжлийн ур чадвараар манлайлан ажиллана.

#### Үнэт зүйлс

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Манлайлал, Инновац, Байгууллагын соёл

ЭРҮҮЛ МЭНД - Эрүүл хүн - Баялаг бүтээгч

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА - Аюулгүй ажиллагааг улам бататгаж, салбартаа тэргүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИН- Дэлхийн жишигт нийцсэн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлж, хамт олон, харилцагч, түнш, олон нийтийн болон тэдний хоорондын эрх ашгийг дээдлэн хүндэлнэ.

МАНЛАЙЛАЛ - Хамтдаа хөгжих, хөдөлмөр эрхлэлтийн тэгш нөхцөл боломжоор хангаж, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хамт олныг бүрдүүлнэ.

ИННОВАЦ - Стратегийн ач холбогдол бүхий үнэ цэнтэй, хязгаарлагдмал байгалийн баялгаар ISO стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг БИД үйлдвэрлэнэ.

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ - Бид бие биеэ хүндэтгэн, үнэнч шударга, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллана. Бид хамтын шийдвэр гаргаж, багийн гишүүн бүрийн оролцоотойгоор ажлыг үр бүтээлтэй, цаг хугацаанд нь хийж гүйцэтгэнэ.

### 1.2 Тусгай зөвшөөрөл, лиценз

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хүрээнд, Засгийн Газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 2,887.85 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын MV-021483 тоот тусгай зөвшөөрөл олгосон.

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумд орших Овоот хяр нэртэй 1,791.44 га ашиглалтын MV-022843 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр олгосон.

- **Хайгуулын тусгай зөвшөөрөл**

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Овоот хяр нэртэй XV-21670 тоот 22641,51 га талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрөл, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумдын нутагт байрлах Өлзийт овоо нэртэй XV-021671 тоот 16634.29 га талбай бүхий тусгай зөвшөөрөл, Засгийн Газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоол, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших “Хүрэн цав” нэртэй хайгуулын XV-021666 тоот тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон.



Тусгай зөвшөөрөл	Тоо
Ашиглалтын тусгай зөвшөөрөл	2
Хайгуулын тусгай зөвшөөрөл	7
<b>Нийт тусгай зөвшөөрөл</b>	<b>9</b>

## ХОЁР. ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1 ХАБЭА-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн Салхит уулын баяжуулах үйлдвэр нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд ҮЙЛДВЭРИЙН ОСОЛГҮЙ нийт 365 хоног, 1,149,504 хүн/цаг ажилласан байна.

#### Хөдөлмөрийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд



### 2.2 ХАБЭА-н эрсдэлийн удирдлагын хэрэгжилт

Компанийн эрсдэлийн удирдлагыг “ХАБЭА-ийн эрсдэлийн удирдлагын журам”-ын дагуу 4 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

#### 1. Эрсдэлийн удирдлагын үе шат:

- 1.1. Бэлтгэл ажлыг хангах – Эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүнийг баталж, холбогдох мэдээлэл цуглуулсан.
- 1.2. Аюулыг илрүүлэх, тодорхойлох – Ажлын байр, технологийн үйл явц, тоног төхөөрөмж, орчны хүчин зүйлсийг тодорхойлж аюулын жагсаалт гаргасан.
- 1.3. Эрсдэлийг үнэлэх – Эрсдэлийн түвшин, магадлал, нөлөөллийг тооцож, эрэмбэлтэл хийсэн.
- 1.4. Хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх, дахин үнэлэх – Залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хяналтын тогтолцоог баталгаажуулсан.

#### 2. Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн нөхцөлүүд:

- 2.1. Шинээр эхлүүлж буй ажил, төсөл хэрэгжүүлэх үед;
- 2.2. Ажлын байр бүрээр болзошгүй эрсдэлийг тодорхойлох үед;
- 2.3. ХАБЭА-ийн журамд өөрчлөлт орсон, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлсэн үед;
- 2.4. 1 дүгээр зэргийн гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн осол гарсан үед.

#### 3. Хийгдсэн эрсдэлийн үнэлгээний ажлууд:

- 3.1. Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийн эрсдэлийн үнэлгээ
- 3.2. Баяжуулах 2 дугаар үйлдвэрийн эрсдэлийн үнэлгээ
- 3.3. Лабораторийн ажлын байрны эрсдэлийн үнэлгээ
- 3.4. Цахилгаан байгууламжийн “Ерлөг”, “Мандал” дэд станцын эрсдэлийн үнэлгээ

#### 4. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- 4.1. 35 кВт-ын “Гурвансайхан сум – Ерлөг” агаарын шугамд үзлэг хийж, шувуу үүрийг цэвэрлэн богино холболт, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлсэн;
- 4.2. Химийн лабораторид ашиглагдаж буй ацетилен, аргон, хүчилтөрөгчийн хийн 11 манометрийн ажиллагааг шалгаж баталгаажуулсан;
- 4.3. Аюулыг арилгах, орлуулах, инженерчлэлийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч, ажилтнуудыг хамгаалах хэрэгслээр бүрэн ханган, аюулгүй ажиллагааны хандлагыг сайжруулсан;
- 4.4. Хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй ажлуудад 1 дүгээр зэргийн эрсдэлийн хяналт тогтоож, хариу арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан;
- 4.5. Ажлын байрны үзлэг, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн урьдчилсан үзлэгийг тогтмол хийж, илэрсэн үл тохирлыг бүрэн арилгасан.







#### 2.3 Дотоод хяналт болон ажлын байрны үзлэгээр илэрсэн үл тохирлыг залруулсан байдлын хэрэгжилт







Тайлант онд ХАБЭА-н дотоод хяналтын журмын дагуу I болон II дугаар шатны үзлэг шалгалтыг календарчилсан төлөвлөгөөний дагуу компанийн хэмжээнд нийт 16 удаа зохион байгуулж, үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд хамруулан хэрэгжүүлсэн. Үзлэг шалгалтын явцад холбогдох маягтад тэмдэглэл хөтөлж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажилласан. Үзлэгээр нийт 62 үл тохирол илрүүлж, гарч болзошгүй осол аваараас урьдчилан сэргийлэх зорилгоор уг 62 үл тохирлыг бүрэн арилган, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлсэн.

*Зарим үл тохирлыг арилгасан байдал*

№	Байршил	Зураг	Тайлбар	Сайжруулсан байдал	Он сар өдөр
1	Үйлдвэрийн гадна орчин		Гадна орчин байгаа томоохон хог хаягдлыг цэвэрлэх		2025.09.02
2	Үйлдвэрийн гадна хаалга		Том хаалганы нугаснууд тасарч, хаалга гажсаныг засварлах		2025.09.10

3	Мушгиа ангилуурын хэсэг		Мушгиа ангилуурын хаягжилтыг хийх		2025.09.09
4	Усан сан-3		3 дугаар сангийн гадна сендвич хууларсаныг хадах, засварлах		2025.09.21
5	Усан сан-1		Явган шатыг хөлд тэглэхгүй болгож үзүүртэй хэсгийг тайрах		2025.09.06
6	Худаг-7		Худгийн тагны хүрээг бетонд хадаж, бэхлэх		2025.09.17
7	Худаг-6		Шатыг өндөрлөж аюулгүй болгох		2025.09.12
8	Худаг-7		Дээврийн хэсгийг битүүлж, засварлах		2025.09.13

9	Худаг-4		Гадна ил кабель утсыг далдлах		2025.09.15
10	Худаг-12		Худгийн амсар таг тагны хүрээг засварлаж, бэхлэх		2025.09.19
11	Дээд кемп		Үйлдвэрийн бүсийн зорчих хэсгийн паркийн талбайгаас иргэн, ажилтан аюулгүй зорчих үүднээс явган гарцын хэсгийн шатыг шинээр хийж сайжруулан бэртэх, гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.		2025.09.29
12	Баяжуулах 1 дүгээр үйлдвэр		Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийн барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангуулан байгууламжийн дээвэр дээр тогтсон шороог сар тутам цэвэрлүүлэн цөмрөлт, нуралт өгөхөөс өмчийн эвдрэл үүсэх, ажилтан гэмтэх, бэртэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.		2025.09.30

13	Хаягдлын даланг		<p>Хаягдлын далангийн байгууламжийн технологийн замууд болон пост-4 хажуу талд, кек буулгах талбайн талд зэрэг газруудад мэдээлэх, сануулах, зам тээврийн аваар ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Шинээр ирсэн тэмдэгтүүдийг нэмэлтээр уурхай эрсдэлтэй газруудад байрлуулсан.</p>		2025.09.01
14	1-р усан сангийн хажуу талаас нөхөн сэргээлтийн 1-р овоолго хүртэл		<p>1 дүгээр усан сангийн хажуу талаас нөхөн сэргээлтийн 1 дүгээр овоолго хүртэл шинээр хашааг барьж СУБҮ-ийн бүсэд гаднаас хүн ба автомашин, мал орохоос урьдчилан сэргийлэн гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.</p>		2025.08.28
15	Ажилчдын амрах кемпгээс ШНП-1 хүртэл		<p>СУБҮ-ийн баруун тал баруун хойд талаас гаднын хүн ба автомашин, мал орох, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.</p>		2025.08.28

## 2.4 Галын аюулгүй байдал хангаж ажилласан байдал

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг шинэчлэн боловсруулан ажиллаж байна. Салхит уулын баяжуулах үйлдвэрийн хэмжээнд СУБҮ-ийн ахлах инженерээр ахлуулан бүх онцгой объектуудад ХАБЭА-н I шат ба II шатны үзлэгийг

Галын аюулгүй байдлын бэлэн байдлыг шалгаж ажилласан. Онцгой байдлын газрын гал түймрийн хяналтын улсын байцаагч “Эрдэнэс” ажилчдын амрах байр, хоол үйлдвэрлэлийн газар, уурхайн оффис, ШТС, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах зэрэг газруудад галын аюулгүй байдлын үзлэг хийж шалгуулан ажилласан.

**Галын гидрант** - Үзлэг шалгалтаар гидрантын хэвийн ажиллагаа бүрэн бүтэн. ГУХ-ын бэлэн байдлыг хангаж Баяжуулах 1, 2 дугаар үйлдвэрүүдийн гидрантуудын уян хоолой, хошуу, холбох эд ангиуд болон усан хангамжийн даралтуудыг шүршиж, шалгасан.

**Галын хор** - ХАБ-н үзлэг шалгалтыг хийж тэмдэглэл хөтөлж ажилласан. Гал аюулгүй байдлын хүрээнд үзлэг шалгалтаар галын сараануудыг будах, гал унтраагууруудыг шалгах, арчиж цэвэрлэх мөн даралтгүй болсон ашиглах боломжгүй галын хорыг цэнэглүүлэх арга хэмжээг авч ажилласан.

**Галын сарай** - Галын сарайны үзлэг шалгалтыг тогтмол хийж, элэгдэж муудсан багаж хэрэгслийг нэмсэн, галын сарааны элснүүдийг шинээр сольж ажилласан.

**Аваарын дуут дохио** - Хэвийн

## **2.5 ХАБЭА-н дадал, хэвшил**

### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, ур чадвар олгох ажлын хэрэгжилт**

Тайлант хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр тутмын зааварчилгаанд 133,601 ажилтан, шинэ ажилтан болон өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалт 647 хүнд, зочдын зааварчилгаанд 285 иргэнд, ХАБЭА-н сургалтад 2,555 ажилтнууд, ажлын байрны давтан зааварчилгаанд 5,275 ажилтан тус тус хамрагдсан.

## **ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

### **3.1 Байгаль орчны зөрчлийн үнэлгээ**

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан " Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу боловсруулж Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны А/420 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулан дүгнүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд 98%-ийн гүйцэтгэлтэйгээр дүгнэсэн.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар хянуулан батлуулж үйл ажиллагаа явуулж байгаа



бөгөөд 2020-2025 оныг дуустал Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлсэн байдлыг доорх хүснэгтэд харуулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2020	2021	2022	2023	2024	2025
Орон нутгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр дүгнүүлсэн хувь, гүйцэтгэл	90.1%	91.4%	92.4%	100%	96.8%	98%

### 3.2 Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ

#### • Ус ашиглах гэрээ, хаягдал усны дүгнэлт

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргааны 10 дугаартай ус ашиглуулах гэрээ, 2025 оны 02 дугаар сарын 25-нд ус бохирдуулсны төлбөрийн гэрээг байгуулсан. Мөн Усны газраас хаягдал усны дүгнэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр гаргуулж, ус бохирдуулсны төлбөр тооцоог хуулийн дагуу төлж ажилласан.



#### • 2025 онд ашигласан усны хэмжээ

№	Ус ашиглалтын төрөл	Эх үүсвэр	Ашигласан усны хэмжээ
1	Үйлдвэрлэлийн хэрэглээнд ашигласан ус	Гүний худгууд, усан сангаас авч ашигласан.	223,860 м <sup>3</sup>
2	Унд ахуйд ашигласан ус		7,798 м <sup>3</sup>
3	Зам талбайн усалгаанд ашигласан ус	Шүүрлийн уснаас авч хэрэглэсэн.	3,270 м <sup>3</sup>
4	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд ашигласан ус		8,400 м <sup>3</sup>
<b>НИЙТ АШИГЛАСАН УСНЫ ХЭМЖЭЭ</b>			<b>243,328 м<sup>3</sup></b>

#### • Ил уурхайн шүүрлийн усны ашиглалт

2025 оны төлөвлөгөөний дагуу ил уурхайн устай хэсэгт нэвтрэлт явуулаагүй бөгөөд карьерт газрын доорх ус шүүрэн орж ирээгүй, түвшин нэмэгдээгүй болно. Тус карьерт борооны улмаас үүссэн байсан усыг шавхаж, ногоон байгууламж, зам талбайн усалгаа арчилгаанд ашигласан болно.



**Зам талбайн усалгаа, арчилгаа:** Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан

өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэж байна. 2025 онд нийт 3,270 м<sup>3</sup> усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.

**Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа:** Кемп болон оффис, уурхайн ойр орчимд тарьсан мод, зүлэг, эрдэнэс төглийн моднуудад 04 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд нийт 210 удаагийн усалгааг зохион байгуулсан. 2025 онд бүх нийтээр тарих өдөрлөгийн хүрээнд хавар 21,000 мод, намар 53,000 мод тарьсан бөгөөд нийт 74,000 мод тарих ажлыг зохион байгуулж ажилласан. Нийт 8,400 м<sup>3</sup> усыг ногоон байгууламжийн усалгаанд ашигласан.



### 3.3 Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдэж 3 сая мод тарих үүргийг хүлээсэн.




“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь өмнөх жилүүдэд 437,555 ширхэг мод тарьсан. Харин 2025 онд Салхит уурхайн Эрдэнэс төгөлд хаврын бүх нийтээр мод тарих өдрүүдээр 20,000, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдээр 53,000, Баянхонгор аймагт

25,000, Шинэ Хархорум хотын ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу 21,919 ширхэг мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд 4,000 ширхэг шинэс модыг намрын улиралд нэмэлтээр тарьж буюу нийт 123,919 модыг тарьсан. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 564,474 мод бутыг тарьж ургуулж байна.

Цаашид өмнөх жилүүдэд тарьж ургуулсан мод бүхий талбайнуудыг үргэлжлүүлэн арчлах бөгөөд 2026 онд хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдийн хүрээнд нийт 50,000 ширхэг мод бутыг тарьж ургуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоо болон сангуудын төлөөллүүдтэй буюу Тэрбум мод сан, Онги гол төрийн бус байгууллагуудын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж



үйл ажиллагаа явуулж буй орон нутагт хийж хэрэгжүүлж буй ажлуудад уялдаа холбоотой хамтарч ажиллах ажлын саналыг солилцож ажилласан.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд байрлах 4,8 га талбайд мод тарих, усалгааны систем, ус нөөцлөх сав,

харуул хамгаалалтын байр барих ажлыг хийж гүйцэтгэсэн.

### 3.4 Салхитын мөнгө-алтны үндсэн ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөнөөс 2025 онд хийж гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажил

Техникийн нөхөн сэргээлт нь уурхайн ашиглалт дууссаны дараа газрын гадаргыг тэгшилж, ус тогтохоос сэргийлэх, эвдэрсэн газрын хэлбэржилтийг засах ажил юм.

#### Хийж гүйцэтгэсэн ажлууд:

Д/д	Ажлын төрөл	Хугацаа	Хэмжээ талбай / га /		Ашигласан техник, төхөөрөмж
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>Техникийн нөхөн сэргээлт</b>					
1	Хөрсний овоолго-1	2025-VII-IX	11.4	12.2	Бульдозер
2	Хөрсний овоолго-2		8.1	11.6	
<b>Нийт</b>			<b>19.5</b>	<b>23.8</b>	
<b>Биологийн нөхөн сэргээлт</b>					
1	Хөрсний овоолго-1	2025-VII-IX	5.0	5.0	Экскаватор, Дамп, Ковш

#### Гүйцэтгэсэн байдал:

- Эвдэрсэн газрын бүх хэсгийг тэгшилж, хажуугийн өнцгийг 10-16 градус болгосон.
- Усны урсгалын чиглэлийг байгалийн дагуу өөрчилж, хашлага хийсэн.
- Тариалах хөрсийг 20-30 см зузаантайгаар дэвсэж, үндэсжүүлэгч түрхлэг хийсэн.

#### ➤ Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлт нь тэгшилсэн газар дээр хөрсний үржил шимийг сэргээж, ургамалжуулалт хийх үйл явц юм.

#### Гүйцэтгэсэн байдал:

Ажлын төрөл	Хэмжээ	Үр ашигласан хэмжээ	Ургамлын төрөл
Үрсэлгээ хийх	5.0 га	180 кг	Хиаг, таана, далий лууль
Органик бордоо хийх	5.0 га	12 тн	Компост, адууны бууц
Улирлын арчилгаа	4.5 га	2 удаа	Усан усалгаа, хортон устгал


### Тайлбар:

- Үрийг хавар, борооны өмнөхөн суулгасан.
- Бордоог хөрсний шинжилгээнд тулгуурлан хийсэн.
- 85–90%-ийн соёлолтой ургамал ургасан нь нөхөн сэргээлтийн үр дүн сайн байгааг харуулж байна.

*Хөрсний 2 дугаар овоолго анхны зураг*



*Хөрсний нөхөн сэргээлт хийсний дараах зураг*



Ил уурхайн хаягдал хөрсний овоолгыг техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу 16<sup>0</sup> налуутайгаар 6.9 га талбайг налуулан түрж 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хүлээлгэн өгсөн. Тухайн талбайд маркшейдерийн хэмжилт, хяналтын ажлыг стандартын дагуу баримтлан гүйцэтгэсэн бөгөөд хэмжилт, зураглалын ажилд **CHCNAV-I89 2 долгионы GPS болон MATRICE 350 RTK дроны хэмжилтийг лиценз бүхий Datamine** программ хангамж ашиглан бодсон болно. Хаягдал хөрсний овоолго дунджаар 10<sup>0</sup>-16<sup>0</sup> налуутай 11.6 га талбайд 223,243м<sup>3</sup> хөрсийг налуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийсэн.

## ДӨРӨВ. НЭГДЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НИЙЦҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

### 4.1 Тайлант оны онцлох ажлууд

#### ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД БОЛОН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

##### Салхит мөнгө-алтны үндсэн орд (MV-021483)

- “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах Техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол II”-ыг 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулсан.
- Салхит уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан 23,8 га талбайд 388,380.24 м3 уулын цулыг түрж тэгшилсэн бөгөөд хаягдлын овоолго 1, 2-ыг 110-160 градус налуужуулж явцын техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.

##### Салхит – Үүсмэл орд

- Үүсмэл ордод дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
  - Геофизикийн цахилгаан эсэргүүцлийн томографын хайгуулын ажил;
  - Геохимийн сорьцлолтын ажил;
  - Хайгуулын өрөмдлөг /малталт/-н ажил;
  - Дээжлэлтийн ажил;
  - Лабораторийн ажил;
  - Байр зүйн зураглал
  - Хагас үйлдвэрлэлийн технологи туршилтын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.
- Үүсмэл ордын геофизикийн үр дүн болон далангуудыг бүрэн төлөөлөхүйц газарт цооног төлөвлөн урвуу эргэлтэт өрмөөр 9 цооног өрөмдөж 75 ширхэг дээжийг лабораторид шинжлүүлсэн.
- Герман-Монголын хамтарсан Ашигт малтмал Технологийн их сургуулийн гүйцэтгэсэн “Флотацийн хаягдлыг дахин ашиглах технологийн судалгааны ажил”-ыг хийж гүйцэтгэсэн.
- БНХАУ дах “Эриез Магнит” ХХК-ийн лабораторид технологи туршилтын ажлыг гүйцэтгүүлсэн.
- Баяжуулах 1 дүгээр үйлдвэрт хаягдлыг боловсруулах 46 цаг, Баяжуулах 2 дугаарт үйлдвэрт 48 цагийн туршилтын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.
- Нөөцийн тайлан боловсруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- ТЭЗҮ боловсруулах ажил 60%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна.

##### Салхит – Зүүн алтны үндсэн орд

- Салхитын Зүүн алт мөнгөний үндсэн ордын анхдагч болон исэлдсэн хүдрийн технологи туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Салхит төслийн “Зүүн” алт-мөнгөний үндсэн ордын нөөцийн тайланг ЭБМЗ-ийн Хайгуулын асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 2025 оны 10 дугаар

сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус ордын нөөцийг 0.2 гр/тн захын агуулгаар В+С зэрэглэлийн 1,105,152 тн исэлдсэн хүдэрт 0.69 гр/тн алтны дундаж агуулгатай 764.04 кг алт, В+С зэрэглэлийн 3,859,973.3 тн анхдагч хүдэрт 0.82 гр/тн алтны дундаж агуулгатай 3,156.1 кг алт, нийт 4,965,125.3 тн исэлдсэн болон анхдагч хүдэрт агуулагдах 3,920.14 кг алтны нөөцийг бүртгүүлсэн.

- Салхит төслийн "Зүүн" алт-мөнгөний үндсэн ордын хүдрийн хагас үйлдвэрлэлийн технологи туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Зүүн алт мөнгөний үндсэн ордын Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил 50%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна.

#### **Овоот хяр төсөл – Хойд бүргэд алтны үндсэн орд (MV-022843)**

- Овоот хяр төслийн "Хойд бүргэд" алтны үндсэн ордод 2020 онд хийгдсэн нөөцийн тооцоонд тодотгол оруулах ажлын хүрээнд нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэж, тодотгол нөөцийн тайланг захын агуулгыг 0.2 гр/тн-оор тооцож Бодитой В зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 48.56 тонн алт, Боломжтой С зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 3.65 тонн алт, нийт В+С зэрэглэл бүхий 52.21 тонн алтны нөөцийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших MV-022843 тоот Овоот хяр төслийн "Хойд бүргэд" алтны үндсэн ордын нарийвчилсан Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

#### **Овоот хяр төсөл – Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай (XV-021670)**

- 2024 оны сансрын зургийн тайлалтын үр дүнд Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2 эрлийн талбай шинээр ялгасан. Шар хөндий эрлийн талбайн баруун хойд хэсэгт шинээр ялгасан Эрлийн талбай 1-т дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Эрлийн маршрут- 28.1 т/км

- Цэглэн сорьц-8ш
- Талбайн зураглал-130 га

Шар хөндий эрлийн талбайн баруун урд хэсэгт шинээр ялгасан Эрлийн талбай 2-т дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Эрлийн маршрут- 24.7т/км
- Цэглэн сорьц- 6ш
- Талбайн зураглалын ажил- 122.4 га

#### **Өлзийт Овоо төсөл - Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай (XV-021671)**

- Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн Баян Овоо эрлийн талбайд сульфидын эрдэсжилттэй бүсийг гүнд нь илрүүлэх зорилгоор 600-1000м урттай, 9 шугамын дагуу 8т/км хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

### **Хүрэнцав төсөл (XV-021666)**

- Хүрэнцав алтны үндсэн ордын эрэл хайгуул, өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний ажил (Байгаль орчны төлөв байдлын тайлан боловсруулсан).
- Технологи туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Уусгалтын аргаар хамгийн өндөр металл авалттай (Анхдагч хүдэрт 91.46% исэлдсэн хүдэрт 91.25%).
- “Эрдэнэ Монгол” ХХК-тай хамтран Хүрэнцав алтны үндсэн ордын Гидрогеологийн судалгааны ажлыг бүрэн хийж дууссан.

### **Мухар хар толгой, Довжоот, Халзан төсөл**

- Мухар хар толгой (XV-021667) төслийн талбайд 17 суваг буюу 3619.69 метр куб суваг малталтын ажлыг хувирал эрдэсжилт бүхий бүсэд хийж гүйцэтгэсэн. Сувгаас 633 ширхэг ховилон сорьцлолт хийж лабораторид хүргүүлсэн.
- Халзан (XV-021669) төслийн талбайн гадаргад илэрсэн хувирал эрдэсжилт, илрэлийг гадаргын түвшинд үнэлэх, чулуулгийн хил заагийг тогтоох зорилгоор 11ш суваг буюу нийт 1719.12 метр куб суваг малталтын ажлыг гүйцэтгэсэн.

### **ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД**

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2025 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 41,000 ширхэг хайлаас мод, Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдэд 33,000 ширхэг хайлаас модыг тус тус Салхит уурхайн “Эрдэнэс төгөл” болон 1 дүгээр постын урд тарьсан. 2025 онд нийт жилийн эцсийн байдлаар 74,000 ширхэг хайлаас модыг тарьсан.
- Бүгд Найрамдах Солонгос Улсын “KIGAM” судалгааны институттэй чухал ашигт малтмалын судалгааны чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэ үеэр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бүрэлдэхүүн компани болох “Эрдэнэс алт ресурс” ХХК нь “Самсунг” групптэй 17 сая ам.долларын мөнгөний баяжмал нийлүүлэх гэрээг байгуулсан.
- Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутаг дэвсгэрт байрлах “Хайрханы ар” нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, эзэн холбогдогчгүй байгаа талбайд хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

### **“ЭРДЭНЭС БОНД”-ЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ**

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс тэтгэвэр авагч өндөр настан иргэдийг тэтгэвэр барьцаалсан зээл, зээлийн хүүгийн өрийн дарамтаас

чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг гарган, ажлын хэсэг байгуулагдан, байгалийн баялгийн орлогын өгөөж буюу Салхитын мөнгөний ордын орлогоос нэг удаа төлөх хуулийн төслийг боловсруулан, Улсын Их Хурлаар хэлэлцүүлснээр “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх” хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан.

- Салхит мөнгө-алтны үндсэн ордын 500-600 гр/тн мөнгөний агуулгатай Хүдэр борлуулах гэрээгээр, Өвөр Монголын “Хао Чень худалдааны компани”, “Рүи Гө” уул уурхайн компани болон “Байгаль хамгааллын технологийн Кэ Ди” компаниас 1 тн хүдрийг 100 ам.доллаар борлуулах нөхцөлтэйгөөр 2020 онд 20 сая ам.доллар, 2021 онд 35.8 сая доллар нийт 55.8 сая ам.доллар;
- Үйлдвэрлэсэн баяжмалаас 13,000-16,000 гр/тн агуулгатай, 63-69%-ийн баяжмал борлуулалтын үнэлгээний хувьтай борлуулах гэрээний нөхцөлөөр 57 сая ам.долларыг Өвөр Монголын “Жүй Ин” худалдааны компани болон “Трафикура” ПТЕ ЛТД-ээс, 2020 онд 14.2 сая ам.доллар, 2021 онд 52.7 сая ам.доллар, нийт 66.9 сая ам.доллар, нийт 122.7 сая ам.доллар буюу 441.8 тэрбум төгрөгийг урьдчилж орсон орлогоор тус тус хүлээн авсан.

**Компанийн зүгээс 2021 онд “Эрдэнэс-2”, “Эрдэнэс-3” бондын 215.5 тэрбум төгрөгийн үнэт цаасны төлбөрийг төлөх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:**

- Компани нь 2021-2023 онуудад урьдчилгаа төлбөрийг барагдуулахад чиглэн ажиллаж, Өвөр Монголын “Байгаль хамгааллын технологийн Кэ Ди”, Өвөрмонголын “Рүи Гө” уул уурхайн компани болон Өвөрмонголын “Хао Чень” худалдааны компаниудад 2020 онд 200 мян.тн, 2021 онд 450 мян.тн, нийт 650 мян.тн хүдэр тус тус нийлүүлсэн.
- Түүнчлэн “Байгаль хамгааллын технологийн Кэ Ди” компанид 2 мян.тн, “Жүй Ин” худалдааны компанид 3.5 мян.тн, “Трафикура” ПТЕ ЛТД-д 9.3 мян.тн баяжмал, нийт 14.8 мян.тн баяжмал нийлүүлж дээрх өр төлбөрийг бүрэн барагдуулсан.
- Баяжмалын агуулгын бууралтаас сэргийлэх зорилгоор Өвөр Монголын Байгаль хамгааллын технологийн “Кэ Ди” компанид 2022 онд нийлүүлэх байсан 500 гр/тн-с дээш мөнгөний агуулгатай 91,000 тн хүдрийн гэрээг зогсоож, баяжуулах үйлдвэрийн тэжээсэн.
- Өвөр Монголын Байгаль хамгааллын технологийн “Кэ Ди” компанитай байгуулсан хүдэр нийлүүлэх гэрээг зөрчсөнөөр арбитрын маргаан үүсэх, сэтгэл санааны дарамт үзүүлэх, нөлөө үзүүлж байсан ч талуудын хооронд баяжмал нийлүүлэх тохиролцоог амжилттай хийж арбитрын маргаанаас сэргийлж чадсан.
- Нийлүүлэх байсан 500 гр/тн-с дээш агуулгатай 91,000 тн хүдэр нь 9.5 сая ам.долларын үнэлгээтэй байсан боловч бага агуулгатай хүдэртэй хольж баяжмал болгосноор бүтээгдэхүүний үнэлгээг 20.5 сая ам.долларын үнэлгээнд хүргэсэн.

- 500 гр/тн-оос дээш агуулгатай хүдрийн гэрээг цуцалж чадсанаар компанид нийт 58 сая ам.доллар буюу одоогийн ханшаар ойролцоогоор 200 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олох нөхцөлийг бүрдүүлсэн.
- Салхит уулын баяжуулах үйлдвэрийг хүдрийн нөөцөөс үүдэн зогсох эрсдэлээс урьдчилан сэргийлж, цаашид 17-19 сар тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Өвөрмонголын Байгаль хамгааллын технологийн “Кэ Ди” компанитай байгуулсан баяжмал нийлүүлэх гэрээний өр төлбөрийг бүрэн барагдуулж чадсан.


сая.₮

№	Төрөл	Бонд	Төлсөн дүн	2025 оны үлдэгдэл
1	Эрдэнэс-1 бонд	929,973.0	2024 онд: 80,000.0	849,973.0
2	Эрдэнэс-2 бонд	194,085.2	2021 онд: 194,085.2	-
3	Эрдэнэс-3 бонд	21,409.5	2021 онд: 21,409.5	-
<b>Нийт дүн</b>		<b>1,145,355.7</b>	<b>295,494.7</b>	<b>849,973.0</b>

### Салхит мөнгө-алтны үндсэн ордын батлагдсан техник эдийн засгийн үндэслэлийн гүйцэтгэл

Салхитын мөнгө алтны ордыг ашиглах 2021 онд батлагдсан Техник, эдийн засгийн үндэслэлээр 5 жилийн хугацаанд 29.1 мян.тн баяжмал үйлдвэрлэж борлуулах ба мөнгөний дундаж агуулга 18,620 гр/тн байх бол алтны дундаж агуулга 21.5 гр/тн байхаар тооцоолсон. Мөн 488 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, тус төлбөрөөр Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөр болох 1.2 их наядаас тодорхой дүнг төлөлцөх тооцоотой байсан.


Борлуулсан хүдэр (мян.тн)





➤ 2020-2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мөнгөний дундаж агуулга 11,546 гр/тн, алтны дундаж агуулга 13.1 гр/тн бүхий 52 мян.тн баяжмал үйлдвэрлэсэн. Тус онуудад 488 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

➤ Эрдэнэс 1, 2 бондыг төлж барагдуулах, үйлдвэрлэлийг эхлүүлэх зорилгоор, 2020-2022 онд урьдчилж орсон орлогоор санхүүжүүлсэн төлбөрийг 2022 оны 07 дугаар сарын 13-ны өдөр бүрэн төлсөн.

Баяжмал үйлдвэрлэл (тн)



**Борлуулалтын орлого (тэрбум.₮)**

**Цэвэр ашиг (тэрбум.₮)**

**Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр хураамж (тэрбум.₮)**


#### Одоогийн нөхцөл байдал:

Цаашид Салхитын мөнгө-алтны үндсэн ордын батлагдсан Техник, эдийн засгийн үндэслэлээр хүдэр дэх мөнгөний агуулга, эдийн засгийн үр өгөөж буурч байгаагаас шалтгаалан ордын нөөцөөр Эрдэнэс бондын өр төлбөрийг төлж барагдуулах боломжгүй нөхцөл байдалтай байна.

#### 4.2 Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал

##### Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийн хэрэгжилт:

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан бүтэц зохион байгуулалтын дагуу Дотоод хяналтын албанд Эрсдэл, дотоод хяналт хариуцсан 2 мэргэжилтэнтэйгээр эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Толгой компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас Нэгдлийн хэмжээнд Олон Улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангуулах зорилт тавин ажиллаж байгаа ба охин компанийн хувьд батлагдсан Эрсдэлийн удирдлагын болон Дотоод хяналтын журмуудыг мөрдлөг болгон эрхэм зорилгоо хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр ашиг, зөв зохистой, сайн засаглалыг бий болгоход дэмжлэг үзүүлж байна.

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны зорилго, зорилтуудын хүрээнд эрсдэлийн удирдлага, хяналтын чиг үүргээр дараах ажлуудыг тодорхойлон хэрэгжүүлсэн.

- Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгох
- Эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх
- Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хийх хяналт

Тайлант оны бизнес төлөвлөгөөнд хийгдсэн шинжилгээгээр стратегийн 1, гадаад хүчин зүйлийн 2, урьдчилан сэргийлж болохуйц 10, нийт 13 эрсдэлийг тодорхойлон үнэлж, Гүйцэтгэх захирлын А/124-1 тоот тушаалаар хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан улирал бүр тайлагнаж байсан бөгөөд төлөвлөсний дагуу эрсдэлийг бууруулах, зайлсхийх, шилжүүлэх замаар бүрэн хэрэгжүүлсэн.

### Эрсдэлийн үнэлгээ

№	Хариуцах газар	Эрсдэлийн ангилал	Эрсдэл	Магадлал		Нөлөөлөл		Эрсдэлийн түвшин	
				Тайлбар	Тоон утгаар	Тайлбар	Тоон утгаар	Түвшин	Тоон утгаар
1	2	3	4	5	6	7	8	9	10
№	Хариуцах газар, нэгж	Хамаарах ангилал	Учирч болзошгүй эрсдэл	Эрсдэл тохиолдох давтамж	1-5	Эрсдэл бодитоор хэрэгжих үед гарах үр нөлөө	1-5	Бага	1-5
								Дунд	6-10
								Өндөр	12-25
1	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйл ажиллагааны эрсдэл	Мөнгө, алтны нөөц багасаж ордын ашиглалтын хугацаа богиносох эрсдэлтэй	Хүдрийн агууламж буурч, металл авалт буурах магадлалтай байна.	3	Уурхай хаагдах, үйлдвэрлэл зогсох	5		15
2	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйл ажиллагааны эрсдэл	Ажилчид бэртэх, гэмтэх, өвчлөх эрсдэл	ХАБЭА-н тогтмол хяналт алдагдах эрсдэл	2	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх	4		8
3	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйл ажиллагааны эрсдэл	Үйлдвэрлэлийн явцад усны хомсдол үүсэж, үйд ажиллагаа зогсох эрсдэл	Хүйтний улиралд усны нөөц багасах аюултай	2	Үйл ажиллагаа зогсох	4		8
4	Захиргаа, удирдлагын газар	Үйл ажиллагааны эрсдэл	Мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчний хомсдолд орох эрсдэл	Мэргэшсэн боловсон хүчин өөр компанид шилжин ажиллаж байна	4	Үйл ажиллагаа доголдох	5		20
5	Стратеги, бизнес хөгжлийн газар	Зах зээлийн эрсдэл	Өртөг нэмэгдэх, ашигт ажиллагааны түвшин, борлуулалтын орлого буурах, зардал нэмэгдэх эрсдэл	Валютын ханшийн өөрчлөлт, мөнгө, алтны зах зээлийн үнийн хэлбэлзлээс компанийн ашигт ажиллагаанд хамаарах	2	Борлуулалт орлого буурах	4		8

6	Санхүү удирдлагын газар	Үйл ажиллагааны эрсдэл	Төсөв болон бусад хүчин зүйлээс шалтгаалан тухайн ажил, үйлчилгээг бүрэн хийгдэхгүй байх эрсдэл	Бараа үйлчилгээний зах зээлийн үнийн өсөлт болон тендер хүчингүй болох явдал	2	Уурхай, үйлдвэр бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байх	4		8
7	Үйлдвэрлэл, технологийн газар	Стратегийн эрсдэл	Байгаль нөхөн сэргээх зардал өндөр байх эрсдэл	Уурхайн хаалтын үед байгаль орчныг нөхөн сэргээхэд урьдчилан бэлтгэл ажлыг хангах	2	Байгалийн нөхөн сэргээлтийн бүрэн гүйцэд хийх	4		8
8	Үйлдвэрлэл, технологийн газар	БОНЗ-ийн эрсдэл	Үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн эрсдэл	ХАБЭА-н тогтмол хяналт алдагдах байдал	1	Байгаль орчинд хүний эрүүл мэндэд нөлөөлөх	3		3
9	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйл ажиллагааны эрсдэл	Туслан гүйцэтгэгч компанийн зүгээс үүсэх эрсдэл	Гэрээний үүрэг биелүүлэхгүй байх, төлөвлөгөө тасалдах	2	Үйл ажиллагаа доголдох	4		8
10	Үйлдвэрлэл, технологийн газар	БОНЗ-ийн эрсдэл	Байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэл	Байгалийн хүчин зүйл	2	Үйл ажиллагаа доголдох	4		8
11	Стратеги, бизнес хөгжлийн газар	Үйл ажиллагааны эрсдэл	Гэрээний дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа хоцрох эрсдэл	Үйл ажиллагааны доголдол, зогсолтоос хамаарах	2	Борлуулалт, мөнгөн урсгал доголдох	3		6
12	Санхүү удирдлагын газар, Захиргаа удирдлагын газар	Үйл ажиллагааны эрсдэл	Үр ашиггүй, хяналтгүй, зориулалт бус зардал гарах эрсдэл.	Шаардлагатай мөрдөх дүрэм, журам дутуу байгаа байдлаас хамаарах	3	Үргүй зардал гарах, ашигт ажиллагаанд нөлөөлөх	3		9

13	Дотоод хяналтын алба	Үйл ажиллагааны эрсдэл	Уурхайн үндсэн болон туслан компанийн ХАБЭА, тэдгээрийн үйл ажиллагааны доголдох эрсдэл	Ажиллах хүчний нөөц, бүрэн техник тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын хэрэгжилтээс хамаарах	2	Үйл ажиллагаа доголдох	5		10
----	----------------------	------------------------	---	--	---	------------------------	---	--	----

### Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөө

№	Эрсдэл	Эрсдэлийн түвшин		Эрсдэлийн удирдлагын төрөл	Хариу арга хэмжээ	Хийгдэх ажлууд	Эрсдэл хариуцагч	Хугацаа	Шаардагдах нөөц	Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшин
1	2	3	4	5	6	7	8	9	10	
№	Тодорхойлсон эрсдэл	Бага	1-5	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл, стратегийн эрсдэл, гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийн удирдлагын арга хэлбэр: эрсдэлээс зайлсхийх, арилгах, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх,	Тухайн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хийгдэх ажлууд	Хийгдэх ажлыг хариуцаж хийх газар, нэгж	Ямар давтамжтай хийх, эцсийн хугацаа	Төсөв, хүний нөөц зэрэг бусад нөөц шаардлагатай эсэх	Хариу арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх эрсдэлийн доод түвшин
		Дунд	6-10							
		Өндөр	12-25							
1	Мөнгө, алтны нөөц багасаж ордын ашиглалтын хугацаа богиносгох эрсдэлтэй		15	Стратегийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Бүтээмжийг нэмэгдүүлж, зардал бууруулахад чиглэсэн техник, технологийн шийдэл нэвтрүүлэх, уурхайн бүсэд нэмэлт хайгуул хийж нөөц нэмэх, бусад төслүүдийг эхлүүлэх	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Дунд
2	Ажилчид бэртэх, гэмтэх, өвчлөх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж	Эрсдэлээс зайлсхийх	Үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулах, ажилтныг ажлын байран дах осол, мэргэжлээс	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Хүний нөөц шаардагдах	Бага

				болохуйц эрсдэл		шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах. Осол, гэмтэл арилгах төлөвлөгөөг ХАБЭА-н дүрэм журмыг баримтлан боловсруулан хяналт тавих, мөрдөн ажиллах.				
3	Үйлдвэрлэлийн явцад усны хомсдол үүсэж, үйд ажиллагаа зогсох эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Овоолгын эргэн тойронд хөрсний усны хяналтын цооногууд байгуулан, усны чанар, хөрсний усны түвшинд өөрчлөлт гарч буй эсэхийг уурхайн талбай түүний ойролцоо байрлах айл өрхийн унд ахуйн усанд чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын судалгаа шинжилгээ, ажиглалт, хэмжилтийг хийж, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Бага
4	Мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчний хомсдолд орох эрсдэл		20	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Хүний нөөцийн хүчний тогтвортой байдлыг хангах хүрээнд, нэн түрүүнд тулгарч буй ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, инфляцын түвшинтэй уялдуулан цалингийн түвшнийг шинэчлэн тогтоох, нарийн мэргэжлийн ажилтнуудын тогтвортой ажиллах боломж боллоцоог судлан арга хэмжээг авч ажиллах, гадаад болон дотоодын мэргэжил, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах	Захиргаа, удирдлагын газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Дунд
5	Өртөг нэмэгдэх, ашигт ажиллагааны түвшин, борлуулалтын орлого буурах,		8	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Валют, алт, мөнгөний ханшны судалгааг оновчтой хийж, төсөөллийг бодитой тооцох. Өртөг бууруулах судалж шийдвэрлэх	Стратеги, бизнес хөгжлийн газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Бага

	зардал нэмэгдэх эрсдэл									
6	Төсөв болон бусад хүчин зүйлээс шалтгаалан тухайн ажил, үйлчилгээг бүрэн хийгдэхгүй байх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Компанийн худалдан авах төлөвлөгөөнд барааны нэр төрөл, төсөв, өртөг бодитоор тооцох тусгах.	Санхүү удирдлагын газар	2025 онд	Нөөц шаардагдахгүй	Бага
7	Байгаль нөхөн сэргээх зардал өндөр байх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Батлагдсан Хаалтын болон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны нөхөн сэргээлт, сөрөг нөлөөллийг бууруулах ажлуудыг цаг алдалгүй гүйцэтгэх	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Бага
8	Үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн эрсдэл		3	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу уурхайн мониторингийн цэгүүдээс тогтмол хугацаанд дээжлэлт судалгааг хийж гүйцэтгэж, шинжилгээний үр дүнгээр илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай. Мөн байгаль орчны батлагдсан журмын дагуу туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Санхүүгийн нөөц шаардагдах	Бага
9	Туслан гүйцэтгэгч компанийн зүгээс үүсэх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Батлагдсан журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах, ажлын төлөвлөгөөний биелэлтэд тогтмол мониторинг хийх	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Нөөц шаардагдахгүй	Бага
10	Байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэл		8	Гадаад хүчин	Эрсдэлийг бууруулах	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дагаж мөрдөж ажиллах, урьдчилан сэргийлэх	Үйлдвэрлэл, технологийн газар	2025 онд	Санхүү, хүний нөөц шаардагдах	Бага

				зүйлийн эрсдэл		арга хэмжээний сургалтыг тогтмол хийх				
11	Гэрээний дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа хоцрох эрсдэл		6	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Баяжмалын нөөцийг бүрдүүлснээр бүтээгдэхүүн нийлүүлэх үйл явцад тогтмол дүн шинжилгээ хийж ажиллах	Стратеги, бизнес хөгжлийн газар	2025 онд	Нөөц шаардагдахгүй	Бага
12	Үр ашиггүй, хяналтгүй, зориулалт бус зардал гарах эрсдэл.		9	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Санхүүгийн болон дотоодтой мөрдөгдөх дүрэм журамд мониторинг хийж, шаардлагатай тохиолдолд шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх	Санхүү удирдлагын газар, Захиргаа удирдлагын газар	2025 онд	Нөөц шаардагдахгүй	Бага
13	Уурхайн үндсэн болон туслан компанийн ХАБЭА, тэдгээрийн үйл ажиллагааны доголдох эрсдэл		10	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Дотоод хяналтын төлөвлөгөөнд холбогдолтой ажлуудыг тусгаж, хяналтын дүгнэлтийн дагуу арга хэмжээ авах	Дотоод хяналтын алба	2025 онд	Нөөц шаардагдахгүй	Бага

**Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

№	Эрсдэл хариуцагч	Эрсдэл	Эрсдэлийн түвшин		Эрсдэлийн удирдлагын төрөл	Эрсдэлд авах хариу арга хэмжээ	Хийгдэх ажил	Хийгдсэн ажил	Хариу арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрсэн эрсдэлийн түвшин		Тренд
			Бага	1-5					Бага	1-5	
1	2	3	4	5	6	7	8	9	10		
Дугаар	Хийгдэх ажлыг хариуцаж хийх газар, нэгж	Тодорхойлсон эрсдэл	Бага	1-5	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл, стратегийн эрсдэл, гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийн удирдлагын арга хэлбэр: эрсдэлээс зайлсхийх, арилгах, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх	Тухайн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хийгдэх ажлууд	Эрсдэл бууруулахад хийгдсэн ажил, хийгдээгүй тохиолдолд тухайн ажил хийгдээгүй шалтгаан	Бага	1-5	"Тодорхойлсон түвшинтэй харьцуулахад ямар өөрчлөлт орсон" ↑↔↓
			Дунд	6-10					Дунд	6-10	
			Өндөр	12-25					Өндөр	12-25	
1	Үйлдвэрлэл, технологийн газар	Мөнгө, алтны нөөц багасаж ордын ашиглалтын хугацаа богиносох эрсдэлтэй		15	Стратегийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Бүтээмжийг нэмэгдүүлж, зардал бууруулахад чиглэсэн техник, технологийн шийдэл нэвтрүүлэх, уурхайн бүсэд нэмэлт хайгуул хийж нөөц нэмэх, бусад төслүүдийг эхлүүлэх	Үүсмэл ордыг ашиглах технологи туршилтын ажил хийгдэж үйлдвэрлэлийн ашиглалтын хугацааг 2026 онд 2 үйлдвэр бүтэн ажиллах боломжтой. Түүнчлэн Салхитын зүүн ордын ТЭЗҮ хийгдэж, бусад алтны орд ашиглалтын хөрөнгө оруулалт төслүүдийн ТЭЗҮ хийгдсэн.	5	↓	
2	Үйлдвэрлэл, технологийн газар	Ажилчид бэртэх, гэмтэх, өвчлөх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулах, ажилтныг ажлын байран дах осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах. Осол, гэмтэл арилгах төлөвлөгөөг ХАБЭА-н дүрэм журмыг баримтлан боловсруулан хяналт тавих, мөрдөн ажиллах.	ХАБЭА-н дүрэм, журмыг чанд баримтлан ажиллаж эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлон, Олон Улсын стандарт ISO хэрэгжүүлэх ажил 50-аас дээш хувьтай болсон.	5	↓	

3	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйлдвэрлэлийн явцад усны хомсдол үүсэж, үйл ажиллагаа зогсох эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Овоолгын эргэн тойронд хөрсний усны хяналтын цооногууд байгуулан, усны чанар, хөрсний усны түвшинд өөрчлөлт гарч буй эсэхийг уурхайн талбай түүний ойролцоо байрлах айл өрхийн унд ахуйн усанд чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын судалгаа шинжилгээ, ажиглалт, хэмжилтийг хийж, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх	2025 онд усны хомсдол үүсэж үйлдвэрлэл зогсоогүй бөгөөд хаягдлын далангаас дахин ашиглах, шинэ худаг гаргах, хэмнэлттэй зарцуулах зэрэг бүхий арга замаар үйл ажиллагааг усны хомсдолоос болж зогсоогоогүй болно.		6	↔
4	Захиргаа, удирдлагын газар	Мэргэшсэн, боловсон хүчний хомсдолд орох эрсдэл		20	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Хүний нөөцийн хүчний тогтвортой байдлыг хангах хүрээнд, нэн түрүүнд тулгарч буй ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, инфляцын түвшинтэй уялдуулан цалингийн түвшнийг шинэчлэн тогтоох, нарийн мэргэжлийн ажилтнуудын тогтвортой ажиллах боломж бололцоог судлан арга хэмжээг авч ажиллах, гадаад болон дотоодын мэргэжил, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах	Боловсон хүчний тэр дундаа мэргэшсэн уул уурхайн ИТА нарын тогтвортой ажиллах нөхцөлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.		6	↓
5	Стратеги, бизнес хөгжлийн газар	Өртөг нэмэгдэх, ашигт ажиллагааны түвшин, борлуулалтын орлого буурах, зардал нэмэгдэх эрсдэл		8	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Валют, алт, мөнгөний ханшны судалгааг оновчтой хийж, төсөөллийг бодитой тооцох. Өртөг бууруулах судалж шийдвэрлэх	Гадаад хүчин зүйлсийн эрсдэл үүсээгүй, мөнгөний агуулга буурснаас орлого буурсан ч жилийн хэмжээгээр төлөвлөсөн хэмжээндээ гүйцэтгэлтэй байна.		5	↓
6	Санхүү удирдлагын газар	Төсөв болон бусад хүчин зүйлээс шалтгаалан тухайн ажил, үйлчилгээг бүрэн хийгдэхгүй байх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Компанийн худалдан авах төлөвлөгөөнд барааны нэр төрөл, төсөв, өртөг бодитоор тооцох тусгах	Компани худалдан авах төлөвлөгөөгөө хууль, журмын хүрээнд бүрэн хэрэгжүүлсэн.		5	↓

7	Үйлдвэрлэл, технологийн газар	Байгаль нөхөн сэргээх зардал өндөр байх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Батлагдсан Хаалтын болон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны нөхөн сэргээлт, сөрөг нөлөөллийг бууруулах ажлуудыг цаг алдалгүй гүйцэтгэх	Төлөвлөгдсөн ажлууд бүрэн хэрэгжсэн	5	↓
8	Үйлдвэрлэл, технологийн газар	Үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн эрсдэл		3	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу уурхайн мониторингийн цэгүүдээс тогтмол хугацаанд дээжлэлт судалгааг хийж гүйцэтгэж, шинжилгээний үр дүнгээр илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай. Мөн байгаль орчны батлагдсан журмын дагуу туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах	Үүсмэл ордыг ашиглахтай байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	3	↔
9	Үйлдвэрлэл, технологийн газар	Туслан гүйцэтгэгч компанийн зүгээс үүсэх эрсдэл		8	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Батлагдсан журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах, ажлын төлөвлөгөөний биелэлтэд тогтмол мониторинг хийх	Туслан гүйцэтгэгч нарт тусгайлан ХАБЭА-г мөрдөж эрсдэлийг үнэлгээгээ урьдчилан ирүүлэх байдлаар зохицуулалт хийж ажилласан. Төлөвлөгөө бус хяналтаар "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж өгсөн.	5	↓
10	Үйлдвэрлэл, технологийн газар	Байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэл		8	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дагаж мөрдөж ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалтыг тогтмол хийх	Сургалтууд бүрэн хийгдсэн.	5	↓


11	Стратеги, бизнес хөгжлийн газар	Гэрээний дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа хоцрох эрсдэл	6	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Баяжмалын нөөцийг бүрдүүлснээр бүтээгдэхүүн нийлүүлэх үйл явцад тогтмол дүн шинжилгээ хийж ажиллах	Зах зээлийн нөхцөл байдалдаа тохируулан худалдан авагч талуудтай тохиролцон баяжмалын агуулга бүрээр тохирсон нийлүүлэлтийг хийж эрсдэлт нөхцөл байдал үүсгээгүй ажиллаж байна.	5	↓
12	Санхүү удирдлагын газар, Захиргаа удирдлагын газар	Үр ашиггүй, хяналтгүй, зориулалт бус зардал гарах эрсдэл	9	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Санхүүгийн болон дотоодтой мөрдөгдөх дүрэм журамд мониторинг хийж, шаардлагатай тохиолдолд шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх	Компанийн дотооддоо ашиглагдах дүрэм, журам, зааварт мониторинг хийгдсэн.	5	↓
13	Дотоод хяналтын алба	Уурхайн үндсэн болон туслан компанийн ХАБЭА, тэдгээрийн үйл ажиллагааны доголдох эрсдэл	10	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлээс зайлсхийх	Дотоод хяналтын төлөвлөгөөнд холбогдолтой ажлуудыг тусгаж, хяналтын дүгнэлтийн дагуу арга хэмжээ авах	Дотоод хяналтын албанд эрсдэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнтэй болж, төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын ажлуудыг уурхайн бүсэд хийж гүйцэтгэн зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлсэн.	5	↓

## ТАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭНД

### 5.1 Удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нийт орон тооны дээд хязгаарыг 133 байхаар тогтоосон бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор Төлөвлөлт, бизнес хөгжил хариуцсан менежер – 1 орон тоо нэмэгдсэнээр орон тооны дээд хязгаар 134 болсон.

#### “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн удирдлага зохион байгуулалтын бүтэц



### 5.2 Нийт зохион байгуулагдсан сургалтын мэдээлэл

*2025 оны жилийн эцсийн байдлаар*

№	Сургалтын нэр	Аж/цаг	Байгууллага	Хугацаа	Хамрагдсан ажилтны тоо
1	"Бүлгийн сэтгэлзүй" сургалт	8	Монголын цахим институт	03 сарын 21,22	"Салхит" УБҮ-ийн 1, 2-р ээлжийн 38 ажилтан
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт	12	Монголын цахим институт	04 сарын 17- 28	Оффис-50, СУБҮ-1,2-р ээлж-59 хүн
3	Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	14	"Орхон байруг групп" ХХК	5 сарын 23	СУБҮ-ийн 13 ажилтан

4	Өргөх, зөөх, тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	14	Монголын цахим институт	05 сарын 24	СУБУ-ийн 6 ажилтан хамрагдсан.
5	Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	14	Монголын цахим институт	5 сарын 06,07	СУБУ-ийн 5 ажилтан хамрагдсан
6	Аюулгүй жолоодлогын сургалт	6		5 сарын 06,07	СУБУ-ийн 8 ажилтан
7	Авлигын эсрэг хуулийн талаар ерөнхий мэдлэг олгох сургалт	3	Авлигатай тэмцэх газар		Оффис-38 ажилтан
8	Галын идэвхтний сургалт	4	Монголын цахим институт	6 сарын 19,20	СУБУ-1,2-р ээлж-51 хүн
9	Хувь хүний хөгжлийн чиглэлээр	3	“Цахим институт”, Хүний хөгжлийн багш, лектор, судлаач, зохиолч Н.Амарбаясгалан	6 сарын 06-07	СУБУ-1,2-р ээлж-51 хүн
10	Өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалт	14	“Цахим институт”, “Хэрлэн эрдэс хими” ХХК	6 сарын 25,26	СУБУ-ийн 9 ажилтан
11	Хөдөлмөрийн эрүүл ахуйн багц сургалт	14	Монголын цахим институт		СУБУ-ийн 8 ажилтан
12	Анхны тусламжийн сургалт	8	“Цахим институт”, Улаан загалмай нийгэмлэг	6 сарын 19,20	СУБУ-ийн 11 ажилтан
13	Эрсдэлийн удирдлагын сургалт	4	“Жавхлант наяд аудит” ХХК	7 сарын 07	Оффис-21 ажилтан
14	Байгал орчин, нийгэм засаглал (БОНЗ)-ын сургалт	4	Монголын хүрээлэн буй орчны нийгэмлэг	7 сарын 16-17	СУБУ-1,2-р ээлж-42 ажилтан
15	Ажил олгогч, удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалт	8	Монголын цахим институт	9 сарын 05	ЭАР ХХК-ийн удирдлагууд , Туслан гүйцэтгэгч компанийн удирдах ажилтнууд нийт -42
16	Байгал орчин, нийгэм засаглалын сургалт	4	Монголын хүрээлэн буй орчны нийгэмлэг	9 сарын 05	ЭАР ХХК-ийн удирдлагууд , Туслан гүйцэтгэгч компанийн удирдах ажилтнууд нийт -42
17	Нэгдсэн менежментийн тогтолцоо ISO45001 2018, ISO14001 2016 стандартын суурь мэдлэг олгох, танилцуулах сургалт	4	Монголын цахим институт	8 сарын 05 9 сарын 15 8 сарын 07	Оффисын 30 ажилтан Уурхайн 25 ажилтан, ТГ компанийн 5 ажилтан нийт 30
18	“Эрүүл мэндийн сургалт”	2		9 сарын 24-25	СУБУ-ийн ажилтнуудад

19	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний-/KPI/ сургалт	4	Монголын цахим институт	2025.04.12	ЗХНХ-ийн 8 ажилтан
20	Удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалт	8	Монголын цахим институт	2025.09.06	ЭАР ХХК болон Туслан гүйцэтгэгч компаниудын удирдлагууд, ХАБЭА-н мэргэжилтэн-50
21	Эрүүл мэндийн сургалт	4	"Энх төрөхүй" ТББ	2025.12.04,05	СУБУ-ийн 1,2-р ээлжийн 30
<b>Нийт</b>		<b>140</b>	<b>31</b>		<b>574</b>

### 5.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнтэй нийцсэн дотоод журам, зааврын хүрээнд компанийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, баримт бичгийн бүрдүүлэлт, ангилалт, хадгалалт, бүртгэл, ашиглалт, шилжилт хөдөлгөөнийг тогтсон журам, хяналтын дагуу эмх цэгцтэй зохион байгуулан, үйл ажиллагааны тасралтгүй байдал, мэдээллийн ил тод, найдвартай байдлыг ханган ажилласан.

Архивын хэргийг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн хөтлөн явуулах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар байнгын ажиллагаатай “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг байгуулан ажиллуулж, компанийн 2024-2025 оны “Хөтлөгдөх хэргийн нэрсийн жагсаалт”-ын дагуу архивын баримт материалыг хүлээн авах, нягтлан шалгах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулан, уг ажил 100%-ийн биелэлттэйгээр бүрэн дуусгасан.

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь архив, албан бичгийн эргэлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн зохион байгуулах зорилтын хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн нийт 625 ирсэн албан бичиг, мөн холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд рүү илгээсэн 826 албан бичиг, иргэдээс ирүүлсэн 2 өргөдлийг журамд заасан хугацаанд бүртгэж, шийдвэрлүүлэн хариуг албан ёсоор хүргүүлж ажилласан.

УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-тай холбогдуулан цаасан харилцааг цахимжуулан компанийн хэмжээнд ирсэн болон явсан бичгийг Microsoft 365 программыг ашиглан холбогдох удирдлага, албан тушаалтнуудад цахимаар хүргүүлэх ажлыг хэвшүүлэхээр зорин ажилласан. Мөн архивын сан хөмрөгийг цахимжуулах ажлыг эрчимжүүлэн архивд хүлээн авч буй материалуудыг цахим хувилбараар авах ажлыг зохион байгуулсан.

Манай компани нь “Монгол шуудан” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд энэ онд нийт 680 гаруй албан бичгийг шуудангаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж ажилласан байна.

### 5.4 Цахим хуудас, ил тод байдлыг хангах хүрээнд

Компанийн цахим хуудас ( Erdenes Alt Resource LLC) нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах мэдээллийг шинэчилж ажилласан байна. Үүнд:

**Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал**

- 1.1 Компанийн танилцуулга,
- 1.2 Эрхэм зорилго
- 1.3 Компанийн лого
- 1.4 Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмууд
- 1.5 Байгууллагын бүтэц
- 1.6 Компанийн үйл ажиллагаа (Уурхай, Үйлдвэр, Байгаль орчин, ХАБЭА, Төслүүд)
- 1.7 Өргөдөл, гомдлын тайлан

#### **Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

- 2.1 Хүний нөөцийн бодлого
- 2.2 Сонгон шалгаруулалтын журам
- 2.3 Нээлттэй ажлын байрны зар
- 2.4 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журам

#### **Гурав. Төсөв санхүүгийн ил тод байдал**

- 3.1 Санхүү төсөв
- 3.2 Аудитын тайлан
- 3.3 2025 оны хагас жилийн тайлан
- 3.4 Шилэн дансны холбоос
- 3.5 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

#### **Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал**

- 4.1 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам
- 4.2 Тендерийн урилгыг хуульд заасны дагуу байршуулах
- 4.3 Тендерт шалгарсан шалгараагүй оролцогчдын мэдээллийг байршуулах
- 4.4 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- 4.5 Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг тухай бүр байршуулах

Компанийн цахим хуудаст нийтэд мэдээлэх бусад мэдээллүүдийг тухай бүр байршуулан ажилласан. Үүнд:

- ✓ Компанийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл: /49/
- ✓ Уул уурхайн танин мэдэхүй холбоотой мэдээ мэдээлэл: /75/
- ✓ Тендер шалгаруулалт зарлал мэдээлэл: /176/
- ✓ Компанийн төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан: /3/
- ✓ Хууль, тогтоол, дүрэм журам: /25/
- ✓ Авлигын эсрэг: /18/
- ✓ Веб сайтад нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шинэчилсэн мэдээллүүдийг байршуулах: /5/
- ✓ Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн мэндчилгээ: /13/
- ✓ Байгууллагын сошиал дизайн, брэндбүүк хэрэглээ, видео дүрс, постер, брошур, бэлэг дурсгалын зүйлс, мэндчилгээ, урилга, эрхийн бичиг, нэрийн хуудас, ажлын үнэмлэх, компанийн хаягжилт гэх мэт бүх зүйл дээр хяналт тавих, дизайн эх загвар бэлтгэн ажилласан байна.

- ✓ Компанийн лого шинэчлэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгүүлэн албажуулж цахим хуудаснуудад тайлбарын хамт шинэчлэх зэрэг ажлууд хийгдсэн байна.

## ЗУРГАА. ИЛ УУРХАЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 6.1 Уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2025 оны батлагдсан төсвөөр уулын ажил эхний 6 сар бүрэн ажиллаад дуусах байсан ба энэ хугацаанд 1,146 мян.м3 уулын цул хөдөлгөж, 999 мян.м3 хөрс хуулалт, мөнгө 166.0 гр/тн-ийн агуулгатай, алт 0.3 гр/тн-ийн агуулгатай 448 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн. Гүйцэтгэлээр:

- 1,014.0 мян.м3 уулын цул буюу 88%, 848.6 мян.м3 хөрс хуулалт буюу 85%
- Мөнгөний агуулга 149.2 гр/тн буюу 90%, алтны агуулга 0.3 гр/тн буюу 100%-тай хүдэр олборлолт 398.2 мян.тн буюу 89%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үзүүлэлт	Х/н	2025 оны жилийн эцэс		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
Уулын цул	мян.м3	1,146.2	1,014.0	88%
Хөрс хуулалт	мян.м3	999.0	848.6	85%
Хүдэр олборлолт	мян.тн	447.7	398.2	89%
Хүдрийн агуулга	Ag, гр/тн	166.0	149.2	90%
	Au, гр/тн	0.3	0.3	100%

### 6.2 Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2025 оны баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд анхдагч хүдэр дэх мөнгөний агуулга 123.7 гр/тн, алтны агуулга 0.2 гр/тн 675.7 мян.тн хүдэр боловсруулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр:

- Хүдэр боловсруулалт 599.6 мян.тн буюу 89%;
- Боловсруулсан хүдэр дэх мөнгөний агуулга 123.1 гр/тн буюу 100%, алтны агуулга 0.2 гр/тн буюу 100%
- Анхдагч хүдэр дэх металлын хэмжээ мөнгө 73.8 тн буюу 88%-ийн, алт 132.9 кг буюу 85%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үзүүлэлт	Х/н	2025 оны жилийн эцэс		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
<b>Анхдагч хүдэр</b>				
Хүдэр	мян.тн	675.7	599.6	89%
Агуулга	Ag, гр/тн	123.7	123.1	100%
	Au, гр/тн	0.2	0.2	100%
Металл	Ag, тн	83.5	73.8	88%
	Au, кг	157.1	132.9	85%

Салхит уулын баяжуулах үйлдвэр нь тайлант онд мөнгө 6,722.3 гр/тн, алт 11.7 гр/тн агуулга бүхий 9,647 тн баяжмал үйлдвэрлэж, металлын хэмжээ мөнгө 67.3 тн байхаар төлөвлөсөн. Баяжмалын металлын хувьд, мөнгөний металл авалт 80% байхаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр:

- Мөнгөний металл авалт 74% буюу гүйцэтгэл 93%,


- Анхдагч хүдрээс 9,966 тн баяжмал үйлдвэрлэж, гүйцэтгэл 103%;
- Баяжмал дах мөнгөний агуулга 5,679.2 гр/тн буюу 85%, алтны агуулга 7.8 гр/тн буюу 67%;
- Баяжмалын металлын мөнгөний хэмжээ 49.7 тн буюу 74%-тай байна.

Үзүүлэлт	Х/н	2025 оны жилийн эцэс		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
<b>Баяжмал</b>				
Металл авалт	Ag, %	80%	74%	93%
Баяжмалын хэмжээ	тн	9,647	9,966	103%
Баяжмал дах металлын агуулга	Ag,гр/тн	6722.3	5,679.2	85%
	Au,гр/тн	11.7	7.8	67%
Баяжмал дах металлын хэмжээ	Ag, тн	67.3	49.7	74%

### 6.3 Технологийн горим мөрдөж ажилласан байдал

Баяжуулах үйлдвэр нь бутлах хэсэг, нунтаглах хэсэг, флотацийн хэсэг, усгүйжүүлэх хэсэг зэрэг 4 үндсэн хэсгээс бүрдэн ажилладаг.

1 тн баяжмалын өртөг



**Баяжмалын агуулгыг тогтвортой түвшинд барихын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:**

- Агуулгын түвшин өөр 3-4 ширхэг хүдрийн овоолгыг зохих харьцааны дагуу холих
- Эргэлтийн усны хатуулгийг багасгах
- Химийн бодисын зарцуулалтын харьцааг өөрчлөх
- Үйлдвэр тэжээж буй анхдагч хүдрийн нунтаглалтын хэмжээг (0.074) мм-т барих

## ДОЛОО. ҮР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


### 7.1 Борлуулалтын орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний биелэлт

- 2025 оны мөнгө-алтны зах зээлийн төлөв байдал, судалгаа шинжилгээ**

Тайлант онд алтны хувьд, Олон Улсын зах зээл дээр үнэ нь огцом өсөлттэй байсан бөгөөд үүнд геополитикийн тогтворгүй байдал, инфляцын дарамт, төв банкнуудын алт худалдан авалт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Алт нь хөрөнгө оруулагчдын хувьд аюулгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэл хэвээр байж, жилийн туршид үнэ нь тогтвортой өсөх хандлага ажиглагдсан.

Харин мөнгөний хувьд, алттай харьцуулахад үнэ нь илүү хэлбэлзэлтэй байсан боловч аж үйлдвэрийн эрэлт, ялангуяа сэргээгдэх эрчим хүч болон технологийн салбарын хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор өсөлт үзүүлсэн. Мөнгөний зах зээл нь эдийн засгийн нөхцөл байдалд илүү мэдрэмтгий тул үнэ нь алтнаас илүү савлагаатай байсан.

#### 2025 оны зах зээлийн үнийн мэдээлэл




Металл	2025 оны үнэ (дунджаар)	Онцлох өөрчлөлт
Алт (Gold)	~3,400+ USD/унц бодит дундаж	Өсөн тэлсэн, 59% өсөлт
Мөнгө (Silver)	~40 USD/унц орчим	Өндөр эрэлттэй, хувиараа өсөлт

- Үйлдвэрлэсэн баяжмалын мөнгөний агуулгад хийсэн судалгаа**

Компани нь 2025 онд 9,966 тн баяжмал үйлдвэрлэсэн бөгөөд агуулгаар нь авч үзвэл: 4000-7000 гр/тн мөнгөний агуулгатай баяжмал 1 дүгээр улиралд 1,110 тн, 2 дугаар улиралд 2,803 тн, 3 дугаар улиралд 1,758 тн, 4 дүгээр улиралд 130 тн баяжмалыг тус тус үйлдвэрлэсэн байна.

7001-10000 гр/тн мөнгөний агуулгатай баяжмал 1 дүгээр улиралд 1,612 тн, 2 дугаар улиралд 336 тн, 3 дугаар улиралд 173 тн, 2000-3999 гр/тн-ын агуулгатай үйлдвэрлэсэн баяжмал нь 3-р улиралд 719тн, 4-р улиралд 1325тн байна.

**Үйлдвэрлэсэн баяжмалын агуулга (гр/тн)**


Агуулга	Q1	Q2	Q3	Q4
2000-2999	-	-	98	618
3000-4000	9	11	621	707
4001-5000	105	182	1164	123
5001-6000	413	1,197	510	7
6001-7000	583	1,413	84	-
7001-8000	574	246	93	-
8001-9000	636	69	48	-
9001-10000	402	21	32	-
<b>Нийт</b>	<b>2,722</b>	<b>3,139</b>	<b>2,650</b>	<b>1,455</b>

**Компанийн гадаад, дотоод орчны шинжилгээ**

PESTLE хүчин зүйл	Нөлөөлөх хүчин зүйлүүд	Компанид үзүүлэх нөлөөлөл
P – Улс төр, төрийн бодлого	<ul style="list-style-type: none"> <li>Ашигт малтмалын хууль, лиценз</li> <li>Төрийн өмчит компанид тавих хяналт өндөр</li> <li>Татварын бодлого (роялти, ААНОАТ)</li> <li>Экспортын бодлого, гааль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бодлогын өөрчлөлт үйл ажиллагаанд нөлөөлнө</li> <li>Тайлан, хяналтын шаардлага өндөр Татварын өсөлт ашиг бууруулна</li> <li>Гаалийн журам удаашрал үүсгэж болно</li> </ul>
E – Эдийн засаг	<ul style="list-style-type: none"> <li>Мөнгөний дэлхийн үнэ</li> <li>Валютын ханш (USD/MNT)</li> <li>Инфляц, шатахууны үнэ</li> <li>Экспортын зардал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ашигт ажиллагаанд шууд нөлөөлнө</li> <li>Зардлын өсөлт ашиг багасгана</li> <li>Валютын ханш өсөх нь орлого нэмэгдүүлнэ</li> </ul>
S – Нийгэм, хүн ам	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийн хүлээлт</li> <li>Нийгмийн хариуцлагын шаардлага</li> <li>Мэргэжлийн боловсон хүчний дутагдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн дэмжлэггүй бол үйл ажиллагаа доголдох эрсдэл үүснэ</li> <li>Хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай болно</li> <li>Хүний нөөцийн тогтворгүй байдал нь эрсдэл дагуулна</li> </ul>
T – Технологи	<ul style="list-style-type: none"> <li>Баяжуулах технологийн шинэчлэл</li> <li>Автоматжуулалт, алсын хяналт</li> <li>Тоног төхөөрөмжийн элэгдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ технологи бүтээмж өсгөнө</li> <li>Хуучин тоног төхөөрөмж төлөвлөгөөт бус зогсолт, осол үүсгэнэ</li> </ul>

L – Хууль эрх зүй	<ul style="list-style-type: none"> <li>• БО-ны үнэлгээ, нөхөн сэргээлт</li> <li>• ХАБЭА-н стандартад нийцүүлэх</li> <li>• Лицензийн нөхцөл шаардлага</li> <li>• Төрийн худалдан авалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шалгалтын давтамж өндөр</li> <li>• Зөрчил гарвал үйлдвэрлэл зогсох эрсдэлтэй</li> <li>• Тендерийн процесс удаашралтай</li> </ul>
E – Байгаль орчин	<ul style="list-style-type: none"> <li>• Эко стандарт, ISO шаардлага</li> <li>• Усан хангамжийн дутагдал</li> <li>• Усан хангамжийн зөвшөөрөл</li> <li>• Хаягдлын менежмент</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Их хэмжээний зардал шаардана</li> <li>• Байгаль орчны зөрчил нэр хүндэд нөлөөлнө</li> <li>• Тогтвортой байдлын үнэлгээ сайжрах боломжтой</li> </ul>

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2025 онд 9,659 тн баяжмал борлуулж, 185.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 10,403 тн баяжмал борлуулж, 225.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан буюу 121%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үзүүлэлт	Х/н	2025 оны жилийн эцэс		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
Баяжмал борлуулалт	тн	9,659	10,403	108%
1 тн баяжмалын дундаж үнэ	\$/тн	5,651	6,150	109%
Нийт борлуулалт	мян.\$	54,520	63,865	117%
	сая.₮	185,366	225,094	121%

### 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	%
<b>I. ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
<b>1.1</b>	<b>Үндсэн борлуулалтын орлого</b>	<b>185,366,162.20</b>	<b>225,093,801.51</b>	<b>39,727,639.31</b>	<b>121.4%</b>
1.1.1	Исэлдсэн хүдрийн орлого	-	-	-	-
1.1.2	Баяжмалын орлого	185,366,162.20	225,093,801.51	39,727,639.31	121.4%
<b>1.2</b>	<b>Бусад орлого</b>	<b>3,000,000.00</b>	<b>18,119,116.66</b>	<b>15,119,116.66</b>	<b>604.0%</b>
1.2.1	Хүүгийн орлого	-	4,319,962.15	4,319,962.15	100.0%
1.2.2	Түрээсийн орлого	-	871,982.98	871,982.98	100.0%
1.2.3	Даатгалын нөхөн олговрын орлого	-	32,956.16	32,956.16	100.0%
	Алданги торгуулийн орлого	-	2,000.00	2,000.00	100.0%
1.2.4	Цахилгааны борлуулалт	3,000,000.00	8,070,780.27	5,070,780.27	269.0%
1.2.5	Дизель түлш борлуулалт	-	4,786,231.73	4,786,231.73	100.0%
1.2.6	Бараа материалын борлуулалт	-	35,203.36	35,203.36	100.0%
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>188,366,162.20</b>	<b>243,212,918.17</b>	<b>54,846,755.97</b>	<b>129.1%</b>
<b>II. ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
<b>2.1</b>	<b>Бүтээгдэхүүний өртөг</b>	<b>130,664,417.80</b>	<b>142,383,807.32</b>	<b>11,719,389.52</b>	<b>109.0%</b>
2.1.1	Хүдрийн өртөг	-	-	-	-
2.1.2	Баяжмалын өртөг	130,664,417.80	129,690,085.23	(974,332.57)	99.3%
2.1.3	Металлын өртөг	0%	0%	-	-
	Цахилгааны борлуулалт	-	8,070,780.27	8,070,780.27	100.0%
	Дизель түлш борлуулалт	-	4,602,672.01	4,602,672.01	100.0%
	Бараа материалын борлуулалт	-	20,269.81	20,269.81	100.0%
<b>2.5</b>	<b>Нийт зардал</b>	<b>24,001,223.00</b>	<b>22,261,939.53</b>	<b>(1,739,283.47)</b>	<b>92.8%</b>
<b>2.5.1</b>	<b>Цалин хөлс нэмэгдэл урамшил</b>	<b>4,102,293.90</b>	<b>4,101,637.02</b>	<b>(656.88)</b>	<b>100.0%</b>
2.5.1.1	Үндсэн цалин	3,774,433.90	3,774,057.02	(376.88)	100.0%
2.5.1.2	Хоол унааны нэмэгдэл	327,860.00	327,580.00	(280.00)	99.9%
2.5.2	<b>Ажил олгогчоос төлөх НДШ</b>	<b>537,474.70</b>	<b>536,955.61</b>	<b>(519.09)</b>	<b>99.9%</b>
2.5.2.1	Аж ахуй нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	537,474.70	536,955.61	(519.09)	99.9%

2.5.3	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>696,650.00</b>	<b>653,320.65</b>	<b>(43,329.35)</b>	<b>93.8%</b>
2.5.3.1	Түрээсийн зардал	696,650.00	653,320.65	(43,329.35)	93.8%
2.5.4	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>3,174,047.00</b>	<b>3,117,014.98</b>	<b>(57,032.02)</b>	<b>98.2%</b>
2.5.4.1	Бичиг хэргийн зардал	91,067.00	90,946.66	(120.34)	99.9%
2.5.4.2	Тээвэр шатахуун	2,728,570.70	2,690,173.11	(38,397.59)	98.6%
2.5.4.3	Шуудан холбооны зардал	76,800.00	68,758.71	(8,041.29)	89.5%
2.5.4.4	Сонин сэтгүүл захиалгын зардал	2,370.80	2,330.00	(40.80)	98.3%
2.5.4.5	Мэдээлэл технологийн зардал	195,352.40	186,114.32	(9,238.08)	95.3%
2.5.4.6	Хог хаягдал, ариутгал цэвэрлэгээ	25,648.60	24,550.27	(1,098.33)	95.7%
2.5.4.7	Хангамжийн материалын зардал	54,237.50	54,141.90	(95.60)	99.8%
2.5.5	<b>Нормативт зардал</b>	-	-	-	
2.5.5.1	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	
2.5.5.2	Нормын хувцасны зардал	-	-	-	
2.5.6	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>117,268.90</b>	<b>90,412.61</b>	<b>(26,856.29)</b>	<b>77.1%</b>
2.5.6.1	Засварын зардал	101,371.00	77,095.89	(24,275.11)	76.1%
2.5.6.2	Багаж техник хэрэгсэл	15,897.90	13,316.72	(2,581.18)	83.8%
2.5.6.3	Тавилга	-	-	-	
2.5.7	<b>Томилолт зочны зардал</b>	<b>141,609.00</b>	<b>139,961.63</b>	<b>(1,647.37)</b>	<b>98.8%</b>
2.5.7.1	Дотоод томилолтын зардал	33,887.00	32,784.37	(1,102.63)	96.7%
2.5.7.2	Гадаад томилолтын зардал	67,242.00	66,844.22	(397.78)	99.4%
2.5.7.3	Зочин, хүлээн авалтын зардал	40,480.00	40,333.04	(146.96)	99.6%
2.5.8	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>542,962.20</b>	<b>449,564.95</b>	<b>(93,397.25)</b>	<b>82.8%</b>
2.5.8.1	Зөвлөх үйлчилгээ	61,000.00	52,600.00	(8,400.00)	86.2%
2.5.8.2	Банк санхүүгийн үйлчилгээний хөлс	6,000.00	1,038.44	(4,961.56)	17.3%
2.5.8.3	Мэргэжлийн үйлчилгээний зардал	-	-	-	
2.5.8.4	Гэрээгээр гүйцэтгүүлэх бусад ажил үйлчилгээ	156,000.00	156,352.17	352.17	100.2%
2.5.8.5	Даатгалын зардал	139,690.20	129,351.67	(10,338.53)	92.6%
2.5.8.6	Сургалтын зардал	102,732.00	97,994.90	(4,737.10)	95.4%
2.5.8.7	Хурал уулзалтын зардал	12,540.00	12,227.77	(312.23)	97.5%
2.5.8.8	Санхүүгийн аудитын зардал	-	-	-	
2.5.8.9	Техникийн аудитын зардал	65,000.00	-	(65,000.00)	0.0%
2.5.9	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,013,261.60</b>	<b>3,000,407.86</b>	<b>(1,012,853.74)</b>	<b>74.8%</b>
2.5.9.1	Маркетинг зар сурталчилгааны зардал	135,000.00	132,023.51	(2,976.49)	97.8%
2.5.9.2	Нийгэм соёлын арга хэмжээний зардал	3,878,261.60	2,868,384.35	(1,009,877.25)	74.0%
2.5.10	<b>Улсын төсөвт төлөх татвар хураамж</b>	<b>216,332.50</b>	<b>333,870.70</b>	<b>117,538.20</b>	<b>154.3%</b>
2.5.10.1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	
2.5.10.2	Улсын тэмдэгтийн хураамж	4,657.00	5,023.94	366.94	107.9%
2.5.10.3	Автомашин татвар, хураамж	3,718.90	12,044.46	8,325.56	323.9%
2.5.10.4	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	138,008.90	264,850.11	126,841.21	191.9%
2.5.10.5	Ус рашаан ашигласны төлбөр	-	-	-	
2.5.10.6	Хог хаягдлын төлбөр	3,600.00	3,600.00	-	100.0%
2.5.10.7	Газрын төлбөр	66,347.70	48,352.20	(17,995.50)	72.9%
2.5.12	<b>Бусад зардал</b>	<b>10,459,323.20</b>	<b>9,838,793.52</b>	<b>(620,529.68)</b>	<b>94.1%</b>
2.5.12.1	Эрсдэлийн зардал	1,000,000.00	99,785.00	(900,215.00)	10.0%
2.5.12.2	Элэгдэл, хорогдлын зардал	802,000.00	733,843.03	(68,156.97)	91.5%

2.5.12.3	Байгаль орчин нөхөн сэргээлт	4,950,000.00	4,912,550.92	(37,449.08)	99.2%
	Менежментийн төлбөр	3,707,323.20	4,092,614.57	385,291.37	110.4%
	<b>Санхүүгийн зардал</b>	-	-	-	
	Зээлийн хүүгийн зардал	-	-	-	
2.3	<b>Бондын эргэн төлөлт</b>	-	-	-	
	Бондын эргэн төлөлт	-	-	-	
	<b>Үйл ажиллагааны бус орлого, зарлага</b>	-	<b>4,351,227.68</b>	<b>4,331,178.90</b>	<b>99.5%</b>
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны орлого	-	-	-	
	Алданги торгуулийн зардал	-	11,048.78	-	100.0%
	Ахмадын сангийн зардал	-	9,000.00	-	100.0%
	Найдваргүй авлагын нөөц	-	2,910,215.77	2,910,215.77	100.0%
	Гадаад валютын зөрүүгийн гарз	-	1,420,963.14	1,420,963.14	100.0%
<b>IV. АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
4.1	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>33,700,521.40</b>	<b>77,057,869.92</b>	<b>49,197,828.83</b>	<b>228.7%</b>
	ААНОАТ	7,525,130.40	22,279,798.66	14,754,668.26	296.1%
4.1	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>26,175,391.00</b>	<b>54,778,071.26</b>	<b>34,443,160.57</b>	<b>209.3%</b>

## НАЙМ. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

### 8.1 "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн төслүүдийн 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн хувь
<b>Салхит төсөл</b>			
1	Салхит талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-р батлуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулан АМГТГ-р батлуулсан	100%
2	2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-р батлуулах	Төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-р батлуулсан	100%
3	"Зүүн" алт-мөнгөний үндсэн ордын нөөцийн тайлан боловсруулж, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	Салхит төслийн "Зүүн" алт-мөнгөний үндсэн ордын нөөцийн тайланг ЭБМЗ-ийн Хайгуулын асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус ордын нөөцийг 0.2 гр/тн захын агуулгаар В+С зэрэглэлийн 1,105,152 тн исэлдсэн хүдэрт 0.69 гр/тн алтны дундаж агуулгатай 764.04 кг алт, В+С зэрэглэлийн 3,859,973.3 тн анхдагч хүдэрт 0.82 гр/тн алтны дундаж агуулгатай 3,156.1 кг алт, нийт 4,965,125.3 тн исэлдсэн болон анхдагч хүдэрт агуулагдах 3,920.14 кг алтны нөөцийг бүртгүүлэхээр болсон.	100%
4	"Зүүн" алт-мөнгөний үндсэн ордын технологи туршилтын ажил гүйцэтгэх	Салхит төслийн "Зүүн" алт-мөнгөний үндсэн ордын хүдрийн баяжигдах шинж чанарын технологи туршилтын ажлыг гүйцэтгэн тайланг хүлээн авсан. Технологи туршилтын үр дүнд Флотаци-уусгалтын аргаар уусган авах боломжтой болохыг тогтоосон. /Алт-мөнгөний исэлдсэн хүдрийн дээжийг баяжуулах технологи туршилтыг флотаци, уусгалт, гравитаци болон флотаци-уусгалт хосолсон аргуудаар хийж гүйцэтгэсэн. Анхдагч хүдрийн шинжилгээ болон туршилтуудын үр дүнгээс үндэслэн исэлдсэн хүдрээс алт, мөнгийг ялган авах үндсэн арга нь уусгалт байна. Баганан уусгалтын туршилт 37 хоног үргэлжилсэн бөгөөд 1 дүгээр багана 88.29 хувь, 2 дугаар багана 88.07 хувийн алт авалтад хүрсэн/.	100%
5	Үүсмэл ордын нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх	Салхит төслийн "Үүсмэл орд"-ын нарийвчилсан хайгуулын ажлыг өөрийн хүчээр гүйцэтгэж дууссан. Нарийвчилсан хайгуулын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:	100%

		<p>1. Үүсмэл ордын геофизикийн үр дүнд болон далангуудыг бүрэн төлөөлөхүйц газарт цооног төлөвлөсөн.</p> <p>2. УРБ өрмөөр 3 цооног буюу 31 метр өрөмдлөгийн ажил хийж дууссан. Нийт 31 ширхэг дээжлэлт хийж, технологи туршилтад зориулж 24 ширхэг дээж бэлдсэн.</p> <p>3. Урвуу эргэлтэт өрмөөр 6 цооног буюу 44 метр тус тус өрөмдөж дээжлэлтийн ажлыг хийсэн.</p> <p>4. Хаягдлын далан 2,3-т 20х20 метр торлолоор литогеохимийн сорьцлолт хийж 228 ширхэг дээж авч лабораторид хүргүүлсэн.</p> <p>5. Дээрх өрөмдлөгийн ажлаар бэлтгэсэн 75 ширхэг дээжийг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр лабораторид хүргүүлсэн.</p> <p>6. Литогеохимийн 228 ширхэг сорьц, өрмийн 30 ширхэг технологи туршилтад зориулсан дээжийг тусгайлан бэлтгэсэн.</p>	
6	Үүсмэл лабораторийн гүйцэтгэх ордын ажил	Салхит төслийн Үүсмэл ордын литогеохимийн сорьцлолтын нийт 228 ширхэг дээж авч лабораторид шинжлүүлж, 2025 оны 4 сарын 29-нд үр дүнг хүлээн авч, нэгтгэсэн.	100%
7	Үүсмэл ордын нөөцийн тайлан боловсруулж, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	Нөөцийн бүх тооцооллыг хийж, тайлан боловсруулж дууссан. ЭБМЗ-өөс томилогдсон хоёр шинжээчтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна.	95%
8	Эрлийн маршрут (Баруун-1, Баруун-2, Нарийны эрлийн талбай)	Салхит төслийн “Баруун-1, Баруун-2”, “Нарийны” эрлийн талбайнуудад эрлийн маршрут хийсэн.	100%
9	Цэглэн дээжлэлт (Баруун-2, Нарийны эрлийн талбай)	Салхит төслийн “Баруун-2”, “Нарийны” эрлийн талбайнуудад цэглэн дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
10	Лабораторийн ажил (Баруун-2, Нарийны эрлийн талбай)	Дээжийг лабораторийн шинжилгээнд өгч, хариуг хүлээн авсан.	100%
11	“Зүүн” алт-мөнгөний үндсэн ордын нөөцийн тайланд шинжээчийн дүгнэлт гаргуулах	“Зүүн” алт-мөнгөний үндсэн ордын нөөцийн тайланд ажиллахаар ЭБМЗ-өөс томилогдсон 2 шинжээчтэй гэрээ байгуулан ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргуулаад байна.	100%
12	Суурин боловсруулалтын ажил	Суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн	50%
<b>Салхит төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>95%</b>
<b>Овоот хяр төслийн MV-022843 тоот “Хойд Бүргэд (1,791.44 га) алтны үндсэн орд</b>			
13	Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2024 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-р батлуулах	Тус талбайд 2024 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын тайланг боловсруулан АМГТГ-аар батлуулсан	100%
14	Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2025 онд гүйцэтгэх геологи,	Тус талбайд 2025 онд гүйцэтгэх геологи, хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГТГ-аар батлуулсан	100%

	хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулах, АМГТГ-аар батлуулах		
15	Хээрийн ажлын бэлтгэл хангах	Хээрийн ажлын бэлтгэл ажлыг бүрэн хангасан	100%
16	Геотехникийн судалгаа хийх	“Хойд Бүргэд” алтны үндсэн ордын геотехникийн өрөмдлөгийн 4 цооног буюу нийт 800т/м ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. Лабораторийн үр дүнг нэгтгэсэн.	100%
17	Нөөцийн тодотгол тайлан боловсруулах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	Овоот хяр төслийн “Хойд бүргэд” алтны үндсэн ордын тодотгол нөөцийн тайланг захын агуулгыг 0.2 гр/тн-оор тооцож Бодитой В зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 48.56 тонн алт, Боломжтой С зэрэглэлийн исэлдсэн болон анхдагч хүдэрт 3.65 тонн алт нийт В+С зэрэглэл бүхий 52.21 тонн алтны нөөцийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.	100%
18	Усны цогц судалгаа хийх	Овоот хяр тусгай зөвшөөрлийн талбайн болон Хойд бүргэд алтны үндсэн ордын газар доорх усны урсцын хэмжээг тодорхойлох, баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамж болон төслийн унд-ахуйн усан хангамжийн баталгаат эх үүсвэрийг илрүүлэхээр гидрогеологийн цогц судалгааны ажил гүйцэтгэж байгаа ба усны нөөцийн тайланг боловсруулж дууссан. Усны газраас томилогдсон шинжээч нар ажиллаж, шинжээчийн зөвлөмжийн дагуу шаардлагатай засварыг хийж, Усны нөөцийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.	95%
19	Хойд бүргэд алтны үндсэн ордын хагас үйлдвэрлэлийн технологи туршилтын дээж авах	Хойд бүргэд алтны үндсэн ордын исэлдсэн болон анхдагч хүдрийн хагас үйлдвэрлэлийн технологи туршилтын дээж авах ажлыг бүрэн гүйцэтгэж, дээжийг “Трү Ти Ар Си” ХХК-д хүргүүлсэн.	100%
20	Хойд Бүргэд алтны үндсэн ордод 2020-2021 онд өрөмдсөн цооногуудад дахин цооногийн бичиглэл хийж, тайлан боловсруулах	“Хойд бүргэд” алтны үндсэн ордын тодотгол нөөцийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, батлуулсан ба нарийвчилсан ТЭЗҮ-ийг зөвхөн исэлдсэн хүдэрт хийхээр болсон. Мөн 2025 онд гүйцэтгэсэн геотехникийн судалгааны үр дүнд хүдэр агуулагч чулуулаг, хоосон чулуулаг зэрэгт эзлэхүүн жин, хувийн жинг хэмжиж баталгаажуулсан. Иймд эзлэхүүн жин хэмжих ажил, дахин логг хийх ажлуудыг өнөөгийн түвшинд нэн шаардлагатай бус гэж үзэж эдгээр ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.	100%
21	Хойд Бүргэд алтны үндсэн ордод 2020-2021 онд өрөмдсөн цооногуудаас чулуулгийн эзлэхүүн жинг хээрийн нөхцөлд хэмжих, чулуулгийн эзлэхүүн жингийн боловсруулалт хийх		100%
22	Эзлэхүүн жингийн лабораторийн ажил		100%

23	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн шав тэмдэг тавих ажил		-
<b>Хойд бүргэд төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>99%</b>
<b>XV-021670 тоот "Овоот хяр" (13534.47га) хайгуулын төсөл</b>			
24	2024 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын тайлан боловсруулах, батлуулах	Тус хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2024 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын тайланг боловсруулан, АМГТГ-аар батлуулсан.	100%
25	2025 онд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулах, батлуулах	Тус хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2025 онд гүйцэтгэх геологи, хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулж, АМГТГ-аар батлуулсан	100%
26	Талбайн зураглал	Шар хөндий эрлийн талбайн баруун хойд болон баруун урд хэсэгт агаар сансрын зургийн тайлалтаар шинээр хоёр талбай ялгаж, талбайн зураглал, эрлийн маршрут, цэглэн дээжлэлтийн ажил гүйцэтгэсэн. Талбай-1. Шинээр ялгасан талбайн хэмжээнд нийт 28.1 т.км эрлийн маршрут, 8 ширхэг цэглэн сорьц, 130 га талбайд талбайн зураглал хийж гүйцэтгэсэн. Талбай-2. Шинээр ялгасан талбайн хэмжээнд нийт 24.7 т.км, эрлийн маршрут, 6 ширхэг цэглэн сорьц, 122.4 га талбайд талбайн зураглал хийж гүйцэтгэсэн.	100%
27	Эрлийн маршрут		100%
<b>Овоот хяр / XV-021670 / төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>100%</b>
<b>XV-022844 тоот "Овоот хяр-1" (7315.6га) хайгуулын төсөл</b>			
28	XV-022844 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийх хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГТГ-аар батлуулах	Шинээр авсан XV-022844 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийх хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГТГ-аар батлуулсан. (Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор)	100%
29	Анги зохион байгуулалт татан буулгалт	Анги зохион байгуулалтыг хийж, хээрийн ажлыг гүйцэтгэсэн	100%
30	Зүүн бүргэд эрлийн талбайд анхдагч геохими дээжлэлт хийх	Зүүн бүргэд зэс-алтны эрлийн талбайд 9 шугамын дагуу 50*25 метрийн торлолоор 180 ширхэг геохимийн /цэглэн/ дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж "ALS" ХХК-ийн лабораторид дээжүүдийг хүргүүлээд байна. Лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэсэн	100%
31	Зүүн бүргэд эрлийн талбайд цахилгаан зүсэлтийн ажил гүйцэтгэх	Цахилгаан зүсэлтийн 5 т/км ажлыг бүрэн гүйцэтгэж, тайланг хүлээн авсан	100%
32	Зүүн бүргэд эрлийн талбайд суваг малталт, сорьцлолт, нөхөн сэргээлт, ховилон сорьцлолт, баримтжуулалтын ажил гүйцэтгэх	Зүүн бүргэд эрлийн талбайд 2500 куб/метр суваг малталтын ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр 100 хувь буюу 2500 куб/метр суваг малталт хийж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг дуусгасан	100%
33	Зүүн бүргэд эрлийн талбайд гүйцэтгэх	Дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, шинжилгээний хариуг хүлээн авсан	100%

	геологи, хайгуулын ажлын лабораторийн шинжилгээг хийх		
34	Зүүн бүргэд эрлийн талбайн суурин боловсруулалтын ажил хийх	Суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн	50%
<b>Овоот хяр-1 / XV-022844 / төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>92%</b>
<b>“Өлзийт Овоо” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай</b>			
35	Өлзийт овоо талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-аар батлуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулж АМГТГ-аар батлуулсан	100%
36	2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулах	Тус талбайд 2025 онд гүйцэтгэх геологи, хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулж, АМГТГ-аар батлуулсан	100%
37	Баян Овоо эрлийн талбайд нарийвчилсан цахилгаан зүсэлт хийх	Баян Овоо эрлийн талбайн нарийвчилсан цахилгаан зүсэлтийн 8 т/км ажлыг бүрэн гүйцэтгэсэн	100%
38	Баян Овоо эрлийн талбайд хайгуул, геотехникийн судалгааны баганат ерөмдлөгийн ажил гүйцэтгэх	Цооног төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэж, нийт 1102.2 т/м ерөмдлөгийн ажлыг гүйцэтгэж геологийн бүх баримтжуулалтыг хийсэн	100%
39	Баян Овоо эрлийн талбайд лабораторийн ажил гүйцэтгэх	Лабораторийн шинжилгээний хариуг 8 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авсан.	100%
40	Стандарт дээж авах /Cu-Au ийн стандарт дээж/	Oreas-506 (1кг) - 8 ширхэг, Oreas-602 (10гр) - 700 ширхэг, Oreas-604b (60гр) - 90 ширхэг, Oreas-606 (1кг) - 3 ширхэг стандарт дээж авсан	100%
41	Талбайн зураглал хийх	Баян овоо эрлийн талбайд шинээр ялгасан 4 га талбайд талбайн зураглалын ажлыг гүйцэтгэсэн	100%
42	Эрлийн маршрут	Баян овоо эрлийн талбайн зүүн хэсэгт шинээр ялгасан талбайд 50т/км эрлийн маршрут хийсэн	100%
43	Цооног холболт /Баян овоо эрлийн талбайн хэмжээнд/	Ажлыг бүрэн гүйцэтгэж, тайлан хүлээн авсан	100%
44	Суурин боловсруулалтын ажил гүйцэтгэх	Суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн	50%
<b>Өлзийт Овоо төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>94%</b>
<b>Хүрэнцав төсөл</b>			
45	Хүрэнцав талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-аар батлуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулж АМГТГ-аар батлуулсан	100%
46	2025 онд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулах, АМГТГ-аар батлуулах	Хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГТГ-аар батлуулсан	100%

47	Хээрийн ажлын бэлтгэл хангах	Хээрийн ажлын бэлтгэл хангасан	100%
48	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнуудын хэмжээнд агаар сансрын зураг татах, тайлалт хийж хувирлын зураг зохиох	Ажлыг бүрэн гүйцэтгэж, тайланг хүлээн авсан	100%
49	Өрөмдлөгийн ажил, суваг малталт, сорьцлолт, нөөцийн тайлан боловсруулах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	Хүрэнцав хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2025 онд 20,000 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн ба 19,996.4 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж дууссан. Мөн баримтжуулалт, дээж бэлтгэл, сорьцлолтын ажлыг бүрэн гүйцэтгэж, бүх дээжийг лабораторид хүргүүлсэн. Нийт 21,412 тууш метр дээж хөрөөдөлт, 21,412 тууш метр сорьцлолтын ажил гүйцэтгэсэн	90%
50	Лабораторийн шинжилгээ	Өрөмдлөгийн 21,412 ширхэг дээжийг лабораторид хүргүүлсэн. Лабораторийн шинжилгээний ажил үргэлжилж байна. 12 сарын 31-ний өдрийн байдлаар 17,458 дээжийн хариу ирсэн ба шинжилгээний хариуг нэгтгэж байна	85%
51	Хайгуулын 6 тусгай зөвшөөрлийн талбайн геологи, хайгуулын ажилд иж бүрэн зөвлөх үйлчилгээ үзүүлж, Жорк стандартын нөөцийн тайлан боловсруулах	Тендер шалгаруулалтаар шалгарсан “Дата ресурс” ХХК-тай уулзалт зохион байгуулсан. Төслийн талбайд ажилласан	80%
52	Алтны стандарт сорьц худалдан авах	Стандарт сорьц худалдан авсан	100%
53	Байр зүйн зураглал, цооног холболт хийх	Цооног холболтын ажил хийгдэж байна	95%
54	Дээж тээвэрлэлт	Бүх дээжийг лабораторид хүргүүлж, дээж тээвэрлэлтийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн	100%
55	Шинжээчийн дүгнэлт гаргуулах	Лабораторийн үр дүн бүрэн гарах хүртэлх хугацаанд түр хойшлогдсон	0%
<b>Хүрэнцав төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>83%</b>
<b>“Мухар хар толгой” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай</b>			
56	Мухар хар толгой талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-аар батлуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулж АМГТГ-аар батлуулсан	100%
57	2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулах	Хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулсан	100%
58	Хээрийн ажлын бэлтгэл хангах	Хээрийн ажлын бэлтгэл хангасан	100%
59	Анги зохион байгуулалт, татан буулгалт	Анги зохион байгуулалтыг хийж, суваг малталтын ажлыг бүрэн гүйцэтгэсэн	100%

60	Анхдагч геохимийн дээжлэлт 100*100 метр тороор	Туслах ажилчдыг ажиллуулах шийдвэр гаргалт удааширсантай холбоотой хийгдээгүй. Бэлтгэл ажлууд хийгдсэн. 2026 онд үргэлжлүүлэн гүйцэтгэнэ	10%
61	Суваг сорьцлолт, сэргээлт малталт, нөхөн	Талбайн хэмжээнд нийт 1,619.69 метр куб буюу 17 суваг малтаж, 693 ширхэг дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн	100%
62	Лабораторийн шинжилгээ	Дээжийг "ХанЛаб" ХХК-ийн лабораторид хүргүүлсэн. Лабораторийн шинжилгээ хийгдэж байна	90%
<b>Мухар хар толгой төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>80%</b>
<b>Довжоот төсөл</b>			
63	Довжоот талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-аар батлуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулж АМГТГ-аар батлуулсан	100%
64	2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулах	Хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулсан	100%
65	Хээрийн ажлын бэлтгэл хангах	Хээрийн ажлын бэлтгэл хангасан	100%
66	Анги зохион байгуулалт татан буулгалт	Бэлтгэл ажлыг бүрэн хангаж, тендер шалгаруулалтаар сонгогдсон компанитай гэрээ байгуулсан. Гэвч Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутгийн иргэдийн эсэргүүцлээс үүдэн Довжоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн 2025 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг Засаг дарга болон байгаль орчны улсын байцаагч баталгаажуулахгүй байгаагаас тус талбайд төлөвлөсөн геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн	0%
67	Анхдагч геохимийн дээжлэлт		
68	Суваг сорьцлолт, сэргээлт малталт, нөхөн		
69	Лабораторийн шинжилгээ		
<b>Довжоот төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>20%</b>
<b>"Халзан" хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай</b>			
70	Халзан талбайд 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан боловсруулах, АМГТГ-аар баталгаажуулах	2024 оны хайгуулын ажлын тайланг боловсруулж АМГТГ-аар баталгаажуулсан	100%
71	2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулах	Хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж, АМГТГ-аар батлуулсан	100%
72	Хээрийн ажлын бэлтгэл хангах	Хээрийн ажлын бэлтгэл хангасан	100%
73	Сорьцлолт (цэглэн дээж)	Цэглэн дээжлэлт хийж, дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, үр дүнг нэгтгэсэн	100%
74	Суваг сорьцлолт, сэргээлт хийх малталт, нөхөн	Талбайн хэмжээнд 1,719.12 метр куб буюу 11 суваг малтаж, 534 ширхэг дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн	100%

75	Лабораторийн ажил	Дээжийг "ХанЛаб" ХХК-ийн лабораторид шинжлүүлж, үр дүнг хүлээн авч нэгтгэсэн	100%
<b>Халзан төслийн төлөвлөгөөний биелэлтийн хувь</b>			<b>100%</b>
<b>2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b>			<b>86%</b>